



2020 оны 05 дугаар сарын 15
№18 /1120/

ТӨРИЙН МЭДЭЭЛЭЛ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН АЛБАН МЭДЭЭЛЭЛ

**Монгол Улсын
хууль**

**Монгол Улсын Их
Хурлын тогтоол**

**Монгол Улсын
Үндсэн хуулийн
цэцийн дүгнэлт**

**Эрүүгийн хуульд
өөрчлөлт оруулах тухай**

**“Импортын барааны гаалийн
албан татварын хувь, хэмжээ
батлах тухай”**

**тогтоолын хавсралтад өөрчлөлт
оруулах тухай**

**Үндсэн хуулийн цэцэд маргаан
хянан шийдвэрлэх ажиллагааны
тухай хуулийн 15 дугаар
зүйлийн 4 дэх хэсэг Үндсэн
хуулийн холбогдох
заалтыг зөрчсөн эсэх маргааныг
хянан шийдвэрлэсэн тухай**

ГАРЧИГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

189.	Санхүүжилтийн хэлэлцээр соёрхон батлах тухай		866
190.	Эрүүгийн хуульд өөрчлөлт оруулах тухай		866
191.	Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуульд өөрчлөлт оруулах тухай		866

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

192.	Үндсэн хуулийн цэцийн 2020 оны 01 дүгээр дүгнэлтийн тухай	Дугаар 30	867
193.	Хуулийн төсөл буцаах тухай	Дугаар 31	867
194.	Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээр томилох, гишүүнээс чөлөөлөх тухай	Дугаар 34	868
195.	“Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай” тогтоолын хавсралтад өөрчлөлт оруулах тухай	Дугаар 35	868

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

196.	Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 4 дэх хэсэг Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай		870
------	--	--	-----

МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

197.	Монгол Улс болон Олон улсын хөгжлийн ассоциаци хоорондын Санхүүжилтийн хэлэлцээр		882
------	---	--	-----



МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 04 дүгээр
сарын 10-ны өдөр

Улаанбаатар
хот

**САНХҮҮЖИЛТИЙН ХЭЛЭЛЦЭЭР
СОЁРХОН БАТЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Монгол Улс, Олон улсын хөгжлийн ассоциаци хооронд 2020 оны 02 дугаар сарын 07-ны өдөр байгуулсан “Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл”-ийн Санхүүжилтийн хэлэлцээрийг Монгол Улсын Засгийн газрын өргөн мэдүүлснээр соёрхон баталсугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 05 дугаар
сарын 01-ний өдөр

Улаанбаатар
хот

**ЭРҮҮГИЙН ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ
ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.2015 оны 12 дугаар сарын 03-ны өдөр баталсан Эрүүгийн хууль /Шинэчилсэн найруулга/-ийн 29.1 дүгээр зүйлийн гарчгийн, мөн зүйлийн 1 дэх хэсгийн “Түрэмгий дайныг” гэснийг “Түрэмгийлэл, эсхүл дайныг” гэж, мөн зүйлийн 2 дахь хэсгийн, 29.2 дугаар зүйлийн гарчгийн, мөн зүйлийн 1 дэх хэсгийн “Түрэмгий дайн” гэснийг “Түрэмгийлэл, эсхүл дайн” гэж тус тус өөрчилсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2020 оны 05 дугаар
сарын 01-ний өдөр

Улаанбаатар
хот

**ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ
ТУХАЙ ХУУЛЬД ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ**

1 дүгээр зүйл.Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 6.1 дүгээр зүйлийн 1.1 дэх заалтын “Түрэмгий дайныг” гэснийг “Түрэмгийлэл, эсхүл дайныг” гэж өөрчилсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 04 дүгээр
сарын 24-ний өдөр

Дугаар 30

Улаанбаатар
хот

Үндсэн хуулийн цэцийн 2020 оны 01 дүгээр дүгнэлтийн тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 32 дугаар зүйлийн 32.3.3 дахь заалтыг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Цэц зөвхөн Үндсэн хууль хүчин төгөлдөр болж үйлчилсэн 1992 оны 02 дугаар сарын 12-ны өдрөөс хойш гарсан хууль тогтоомж болон албан тушаалтны үйл ажиллагаатай холбогдсон маргааныг хянан шийдвэрлэнэ.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсын Үндсэн хуулийн цэц бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа мөн.”, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино.” гэж заасныг тус тус зөрчсөн байна гэсэн Үндсэн хуулийн цэцийн 2020 оны 4 дүгээр сарын 15-ны өдрийн 01 дүгээр дүгнэлтийг хүлээн зөвшөөрөх боломжгүй гэж үзсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 04 дүгээр
сарын 29-ний өдөр

Дугаар 31

Улаанбаатар
хот

Хуулийн төсөл буцаах тухай

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1. Монгол Улсын Их Хурлын гишүүн Ж.Энхбаяр, Х.Нямбаатар нараас 2020 оны 04 дүгээр сарын 17-ны өдөр Улсын Их Хуралд өргөн мэдүүлсэн Коронавируст халдвар /COVID-19/-ын цар тахлаас урьдчилан сэргийлэх, тэмцэх тухай хуулийн төсөлтэй хамт өргөн мэдүүлсэн Гамшгаас хамгаалах тухай хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах тухай хуулийн төслийг нэгдсэн



хуралдаанд оролцсон гишүүдийн олонх тухайн асуудлаар хууль гаргах шаардлагагүй гэж үзсэн тул хууль санаачлагчид нь буцаасугай.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 04 дүгээр
сарын 30-ны өдөр

Дугаар 34

Улаанбаатар
хот

**Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээр
томилох, гишүүнээс чөлөөлөх тухай**

Сонгуулийн төв байгууллагын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2, 4.5 дахь хэсэг, Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.2 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээр Сайннямбуугийн Баатаржав, Барсүрэнгийн Баасандорж нарыг томилсугай.

2.Рэнцэнгийн Содхүү, Өлзийбатын Энхтөр нарыг Сонгуулийн ерөнхий хорооны гишүүнээс чөлөөлсүгэй.

3.Энэ тогтоолыг 2020 оны 04 дүгээр сарын 30-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2020 оны 05 дугаар
сарын 01-ний өдөр

Дугаар 35

Улаанбаатар
хот

**“Импортын барааны гаалийн албан
татварын хувь, хэмжээ батлах тухай”
тогтоолын хавсралтад өөрчлөлт
оруулах тухай**

Гаалийн тариф, гаалийн татварын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.3 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.“Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 1999 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн

27 дугаар тогтоолын хавсралтын 07 дугаар бүлэгт Саримс “30 хүртэл”, Улаан лооль “30 хүртэл”, Өргөст хэмх “30 хүртэл”, Тарвас “30 хүртэл” гэсэн барааны нэр төрөл нэмсүгэй.

2.“Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 1999 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 27 дугаар тогтоолын хавсралтын 07 дугаар бүлгийн Хүнсний ногоо, зарим ургамлын үндэс булцуу “20 хүртэл” гэснийг “30 хүртэл” гэж, мөн бүлгийн Төмс, Сонгино, Байцай, Шар лууван, Шар манжин тус бүр “20 хүртэл” гэснийг тус бүр “30 хүртэл” гэж өөрчилсүгэй.

3.Үр тариа, тосны ургамал, тэжээлийн таримал, төмс, хүнсний ногооны үрийн гаалийн албан татварын хувь, хэмжээг “0” болгосугай.

4.Энэ тогтоолыг баталсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /У.Хүрэлсүх/-т даалгасугай:

1/энэ тогтоолын 3 дахь заалтад заасан барааны үндэсний кодыг 2020 оны 08 дугаар сарын 01-ний өдрийн дотор батлах;

2/“Импортын барааны гаалийн албан татварын хувь, хэмжээ батлах тухай” Монгол Улсын Их Хурлын 1999 оны 06 дугаар сарын 03-ны өдрийн 27 дугаар тогтоолын 4 дэх заалтаар Улсын Их Хурлаас эрх олгосны дагуу мөн тогтоолын хавсралтын 07 дугаар бүлэгт заасан хязгаарт багтаан барааны гаалийн албан татварын хувь, хэмжээг шинэчлэн тогтоох;

3/дотоодын үйлдвэрлэлийг хамгаалах зорилгоор Дэлхийн худалдааны байгууллагын “Хамгаалалтын арга хэмжээний хэлэлцээр”-т нийцүүлэн “Хамгаалалтын арга хэмжээний журам”-ыг батлах, хэлэлцээрийн хүрээнд үйлчлэх импортын барааны тоо хэмжээний хязгаар болон гаалийн албан татварын хувь, хэмжээг тогтоох.

5.Энэ тогтоолыг 2020 оны 08 дугаар сарын 01-ний өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

**МОНГОЛ УЛСЫН
ИХ ХУРЛЫН ДАРГА**

Г.ЗАНДАНШАТАР



МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН ЦЭЦИЙН ДҮГНЭЛТ

2020 оны 04 дүгээр
сарын 15-ны өдөр

Дугаар 01

Улаанбаатар
хот

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 4 дэх хэсэг Үндсэн хуулийн холбогдох заалтыг зөрчсөн эсэх маргааныг хянан шийдвэрлэсэн тухай

Үндсэн хуулийн цэцийн хуралдааны
танхим 12.00 цаг.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдааныг Үндсэн хуулийн цэцийн гишүүн Ш.Цогтоо даргалж, Үндсэн хуулийн цэцийн гишүүн, Г.Туулхүү, Ш.Солонго, Ц.Нанзаддорж /илтгэгч/, Г.Баясгалан нарын бүрэлдэхүүнтэй, нарийн бичгийн даргаар Б.Мөнхгэрэлийг оролцуулан Үндсэн хуулийн цэцийн хуралдааны танхимд нээлттэй хийв.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанд мэдээлэл гаргагч, иргэн Д.Цэрэнбадам оролцов.

Үндсэн хуулийн цэцийн дунд суудлын хуралдаанаар Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 4 дэх хэсэг Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1, Жаран зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, мөн зүйлийн 4 дэх хэсэг, Далдугаар зүйлийн 1, 2 дахь хэсгийг тус тус зөрчсөн эсэх тухай маргааныг хянан хэлэлцэв.

Нэг. Нийслэлийн Хан-Уул дүүргийн 3 дугаар хорооны оршин суугч, иргэн Ж.Эрхэмбаатар Үндсэн хуулийн цэцэд хандан дараах агуулга бүхий мэдээллийг ирүүлжээ. Үүнд:

“Монгол Улсын Их Хурлаас 1997 оны 5 дугаар сарын 01-ний өдөр баталсан Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Цэц зөвхөн Үндсэн хууль хүчин төгөлдөр болж үйлчилсэн 1992 оны 2 дугаар сарын 12-ны өдрөөс хойш гарсан хууль тогтоомж болон албан тушаалтны үйл ажиллагаатай холбогдсон маргааныг хянан шийдвэрлэнэ.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Жаран зургадугаар зүйлийн 1, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийг дор дурдсан үндэслэлээр зөрчсөн байна.

1. Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар Монгол Улсын Үндсэн хуулийн цэц нь Үндсэн

хуулийн биелэлтэд “дээд” хяналт тавих эрх бүхий байгууллага. Үндсэн хуулийн биелэлтэд тавих хяналт нь хууль тогтоох дээд байгууллага болон бусад байгууллагаас гаргасан хууль, эрх зүйн актын хүрээнд хэрэгжих төрийн дээд хяналт юм.

Гэвч Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасан зохицуулалт нь Цэц “дээд” хяналтаа хэрэгжүүлэх, маргааныг магадлан шийдвэрлэх эрхийг хязгаарласан буюу зөрчжээ. Учир нь Үндсэн хууль нь төрийн дээд хүчин чадал бүхий эрх зүйн акт бөгөөд бусад хууль тогтоомж түүнд нийцэж тохирсон байх ёстой. Үүнийг Монгол Улсын Үндсэн хуулийн Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуульд хууль ... бүрнээ нийцсэн байвал зохино” гэж баталгаажуулсан байдаг. Гэтэл Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар Цэц зөвхөн Үндсэн хууль хүчин төгөлдөр болж үйлчилсэн өдрөөс хойш гарсан маргааныг хянан шийдвэрлэхээр хуульчилжээ. Энэ нь Цэц 1992 оны 2 дугаар сарын 12-ны өдрөөс өмнө гарсан боловч Монгол Улсад үйлчилж, эрх бүхий албан тушаалтнаас хэрэглэж байгаа хууль, бусад шийдвэрийг хянахгүй үр дагаварт хүргэж байна.

2. Цэц зөвхөн Үндсэн хууль хүчин төгөлдөр болж үйлчилсэн өдрөөс хойш гарсан маргааныг хянан шийдвэрлэхээр хуульчилсан тус заалт нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар “Үндсэн хуулийн цэц нь Үндсэн хуулийг зөрчсөн тухай маргааныг иргэдийн өргөдөл, мэдээллийн дагуу ... хянан шийдвэрлэнэ” гэж заасныг зөрчсөн. Иргэд Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасан асуудлаар өргөдөл, мэдээлэл гаргах эрхтэй. Гэвч Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 4 дэх хэсэг нь иргэдийн өргөдөл, мэдээлэл гаргах эрхийг хязгаарлаж байна.

Иймд Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 4 дэх хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын Үндсэн хуулийн цэц бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа мөн”, Жаран зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуулийн цэц нь Үндсэн хуулийг зөрчсөн тухай маргааныг иргэдийн өргөдөл, мэдээллийн дагуу ... хянан шийдвэрлэнэ”, Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино” гэж заасныг тус тус зөрчсөн болохыг тогтоож, хүчингүй болгож өгнө үү.” гэсэн байна.



Хоёр. Нийслэлийн Баянгол дүүргийн 15 дугаар хорооны оршин суугч, иргэн Н.Ариунболд, Хан-Уул дүүргийн 15 дугаар хорооны оршин суугч, иргэн Д.Оросоо нар Үндсэн хуулийн цэцэд хандан дараах агуулга бүхий мэдээллийг ирүүлжээ. Үүнд:

“Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт зааснаар Үндсэн хуулийн цэц нь Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага байхаас гадна Монгол Улсад Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа болдог билээ.

Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих энэхүү Үндсэн хуулийн цэцийн онцгой бүрэн эрх нь Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж, нийгмийн харилцааг зохицуулж байгаа аливаа хууль тогтоомж Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх талаар гаргасан иргэний мэдээлэл, эрх бүхий этгээдийн хүсэлтээр хянан шийдвэрлэх замаар хэрэгждэг.

1992 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр Ардын Их Хурлаас Монгол Улсын Үндсэн хуулийг баталснаар 1992 оны 2 дугаар сарын 12-ны өдрийн 12 цагаас эхэлж БНМАУ-ын Үндсэн хуулиас Монгол Улсын Үндсэн хуулийг Монголын ард түмэн дагаж мөрдөж эхэлсэн.

Гэтэл Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт зааснаар Үндсэн хуулийн цэц зөвхөн 1992 оны 2 дугаар сарын 12-ны өдрөөс хойш гарсан хууль тогтоомжийн маргааныг хянан шийдвэрлэнэ, үүнээс өмнө гарсан хууль тогтоомж /хууль, тогтоол, олон улсын гэрээ/-ийг хянан шийдвэрлэхгүй гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын Үндсэн хуулийн цэц бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа мөн.” гэж заасанд үл нийцэж байна.

Учир нь Монгол Улсад хүчин төгөлдөр аливаа хууль тогтоомж нь Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа дээд хүчин чадалтай Үндсэн хуульд нийцсэн байх шаардлагыг Үндсэн хуулийн Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино.” гэж заасан.

Ардын Их Хурлаас Монгол Улсын Үндсэн хуулийг батлахдаа Монгол Улсын Үндсэн хуулийн хавсралт хууль буюу БНМАУ-ын Үндсэн хуулиас Монгол Улсын Үндсэн хуулийг бүрнээ дагаж мөрдөхөд шилжих тухай хуулийг мөн баталсан байдаг. Уг хуулийн Есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Энэхүү хавсралт хууль нь Монгол Улсын Үндсэн хуулийнхаа нэгэн адил хүчинтэй.” гэж зааж өгсөн.

Хавсралт хуулиар Монгол Улсын Үндсэн хууль хүчин төгөлдөр болох хүртэл дагаж мөрдөж ирсэн бүх хуулийг мөнхүү Үндсэн хуульд харшлахгүй бол цаашид хүчин төгөлдөр дагаж мөрдөх, Монгол Улсын Үндсэн хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн Үндсэн хуульд харшилсан хууль болон эрх зүйн бүх акт, тэдгээрийн заалтыг хүчингүй болсонд тооцох, хууль тогтоомжийг 1996 онд багтаан хийж дуусгах гэх мэт шилжилтийн үеийн харилцааг зохицуулсан байдаг. Өөрөөр хэлбэл, 1996 онд багтаан хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн дээд байгууллагууд хууль тогтоомжийг шинэчлэх, тодруулбал хууль тогтоох эрх мэдлийн хүрээнд 1992 оны 2 дугаар сарын 12-ны өдрөөс өмнө гарсан хууль тогтоомж нь Үндсэн хуульд нийцсэн гэж үзвэл хэвээр үлдээх, гүйцэтгэх мэдлийн хүрээнд 1992 оны 2 дугаар сарын 12-ны өдрөөс өмнө гарсан хууль тогтоомж Үндсэн хуульд нийцсэн гэж үзвэл уг хуулийг хэрэгжүүлэх бүрэн эрхийг Хавсралт хууль олгосон.

Харин хууль тогтоох, гүйцэтгэх эрх мэдлийн хүрээнд Үндсэн хуульд нийцсэн гэж үзсэн боловч, шүүх эрх мэдэл буюу Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих бүрэн эрхийн хүрээнд БНМАУ-ын хууль тогтоомж Үндсэн хуульд нийцээгүй гэж үзвэл Үндсэн хуулийн цэцээс уг хууль тогтоомжид хяналт тавих бүрэн эрхийг маргаан бүхий хуулийн заалт хязгаарлаж байна гэж үзэн энэхүү мэдээллийг Үндсэн хуулийн цэцэд гаргаж байна.

Мэдээлэл гаргагчийн зүгээс 1991 оны 1 дүгээр сарын 04-ний өдөр БНМАУ-ын Бага Хурлаас батлагдсан “Монгол Улсын Засгийн газарт эрх олгох тухай “хууль” Үндсэн хууль зөрчсөн талаар Үндсэн хуулийн цэцэд мэдээлэл гаргасан боловч Үндсэн хуулийн цэцийн гишүүний 2019 оны 3 дугаар сарын 18-ны өдрийн 56 дугаар тогтоолоор Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн дагуу уг хууль Үндсэн хуульд нийцсэн эсэх асуудлыг хянан шийдвэрлэх боломжгүй гэж үзэн маргаан хянан шийдвэрлэх ажиллагаа үүсгэхээс татгалзжээ.

Энэ нь Үндсэн хуулийн цэц 1992 оны 2 дугаар сарын 12-ны өдрөөс өмнө батлагдсан боловч одоо Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж байгаа хууль тогтоомжийг Үндсэн хуульд нийцсэн эсэхийг хянах боломжгүй байгааг харуулж байна.

Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Цэц зөвхөн Үндсэн хууль хүчин төгөлдөр болж үйлчилсэн 1992 оны 2 дугаар сарын 12-ны өдрөөс хойш гарсан хууль тогтоомж болон албан тушаалтны үйл ажиллагаатай холбогдсон маргааныг хянан шийдвэрлэнэ.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын Үндсэн хуулийн цэц бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг



магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа мөн.”, Жаран зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуулийн цэц нь Үндсэн хуулийг зөрчсөн тухай маргааныг иргэдийн өргөдөл, мэдээллийн дагуу өөрийн санаачилгаар ... хянан шийдвэрлэнэ.”, мөн зүйлийн 2 дахь хэсэгт “Үндсэн хуулийн цэц энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндэслэлээр дараахь маргаантай асуудлаар дүгнэлт гаргаж Улсын Их Хуралд оруулна:” гээд 1 дэх заалтад “хууль... Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх;”, 4 дэх заалтад “Хууль ... Үндсэн хуульд нийцээгүй гэж Үндсэн хуулийн цэц шийдвэр гаргавал зохих хууль ... хүчингүй болно.”, Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага ... үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино.”, мөн зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улсын Үндсэн хуулийг 1992 оны хоёрдугаар сарын 12-ны өдрийн 12 цаг буюу арван долдугаар жарны усан бичин жилийн хаврын тэргүүн хар барс сарын шинийн есний идрийн барилдлагаатай өлзийт сайн шар морин өдрийн морин цагаас эхлэн улс даяар дагаж мөрдөнө.” гэсэнд нийцсэн эсэхийг хянан шийдвэрлэж өгнө үү” гэжээ.

Гурав. Нийслэлийн Налайх дүүргийн 7 дугаар хорооны оршин суугч, иргэн Ц.Мөнгөнцацрал Үндсэн хуулийн цэцэд хандан дараах агуулга бүхий мэдээллийг гаргажээ. Үүнд:

“Одоо хүчин төгөлдөр үйлчилж байгаа Үндсэн хууль батлагдсанаас хойш 1988 онд батлагдсан Газрын хэвлийн тухай, 1991 онд батлагдсан Монгол Улсын Засгийн газарт эрх олгох тухай, Бүгд Найрамдах Монгол Ард Улсын тэтгэмжийн тухай, Намын гишүүнээс түдгэлзвэл зохих албан тушаалын тухай, Өмчлөлийн тухай зэрэг 8 хуулийг одоог болтол Монгол Улсын Их Хурлаас хүчингүй болсонд тооцоогүй, хүчин төгөлдөр үйлчилж төрийн захиргааны байгууллага шийдвэр, үйл ажиллагаандаа мөрдлөг болгосоор байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Хавсралт хуулийн Есдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Энэхүү Хавсралт хууль Монгол Улсын Үндсэн хуулийнхаа нэгэн адил хүчинтэй байна.” гэж, Тавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын Үндсэн хууль хүчин төгөлдөр болох хүртэл дагаж мөрдөж ирсэн бүх хуулийг мөнхүү Үндсэн хуульд харшлахгүй бол цаашид хүчин төгөлдөр дагаж мөрдөнө.” гэж тус тус заасан байдаг.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Үндсэн хуулийн цэц энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндэслэлээр дараах маргаантай асуудлаар дүгнэлт гаргаж Улсын Их Хуралд оруулна:” гээд 1 дэх заалтад “... хууль ... Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх” гэж тусгасан. Үүнээс үзэхэд Үндсэн хууль батлагдахаас өмнө батлагдсан дээрх хуулиуд одоог болтол хүчин төгөлдөр үйлчилж Үндсэн хуулийн цэцийн дүгнэлт гаргах маргааны зүйлд хамаарч байхад Үндсэн хуулийн цэцэд

маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Цэц зөвхөн Үндсэн хууль хүчин төгөлдөр болж үйлчилсэн 1992 оны 2 дугаар сарын 12-ны өдрөөс хойш гарсан хууль тогтоомж болон албан тушаалтны үйл ажиллагаатай холбогдсон маргааныг хянан шийдвэрлэнэ.” гэж хуульчилсан байх тул Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1, Жаран зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, мөн зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалтыг зөрчсөн эсэхийг тогтоож, дүгнэлт гаргаж өгнө үү.” гэжээ.

Дөрөв. Нийслэлийн Баянгол дүүргийн 17 дугаар хорооны оршин суугч, иргэн Д.Цэрэнбадам Үндсэн хуулийн цэцэд хандаж:

“Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын Үндсэн хуулийн цэц бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага. Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа мөн”, Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Үндсэн хуулийн цэц энэ зүйлийн 1 дэх хэсэгт заасан үндэслэлээр дараахь маргаантай асуудлаар дүгнэлт гаргаж Улсын Их Хуралд оруулна гээд хууль, зарлиг, Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн бусад шийдвэр, түүнчлэн Засгийн газрын шийдвэр, Монгол Улсын олон улсын гэрээ ...” гэж, Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино.” гэжээ.

Хууль тогтоогч Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Цэц зөвхөн Үндсэн хууль хүчин төгөлдөр болж үйлчилсэн 1992 оны 2 дугаар сарын 12-ны өдрөөс хойш гарсан хууль тогтоомж болон албан тушаалтны үйл ажиллагаатай холбогдсон маргааныг хянан шийдвэрлэнэ.” гэсэн (цаашид “Батлагдсан цаг хугацааны хязгаарлалт” гэх) заалтыг оруулж, Үндсэн хуулийн хяналтыг батлагдсан цаг хугацаагаар хязгаарласан нь Үндсэн хуульд нийцэхгүй, зөрчсөн ердийн хууль, хуульчилсан акт нийгэмд хэрэгж эрх зүйн орчныг бүрдүүлсэн байна.

Хууль зүйн үндэсний хүрээлэн, Улсын Их Хурлын Тамгын газраас авсан мэдээллээр 1992 оны 1 дүгээр сарын 13-ны өдөр батлагдан, хүчин төгөлдөр үйлчилж буй Монгол Улсын Үндсэн хууль батлагдахаас өмнө БНМАУ-ын Их хурал болон БНМАУ-ын Бага Хурлаар батлагдсан 8 хууль, соёрхон баталсан буюу нэгдэн орсон 65 олон улсын гэрээ өнөөдрийг хүртэлх хугацаанд хүчин төгөлдөр үйлчилж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн агуулгаар эдгээр хуулиуд болон соёрхон баталсан буюу нэгдэн орсон Олон улсын гэрээнүүд нь Үндсэн хуульд бүрнээ нийцсэн байх учиртай бөгөөд Үндсэн хуульд нийцсэн эсэхэд Үндсэн хуулийн цэц хяналт тавих бүрэн боломжтой байх ёстой. Үндсэн хуулийн Аравдугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Монгол Улс



Үндсэн хуульдаа харшилсан олон улсын гэрээ, бусад баримт бичгийг дагаж мөрдөхгүй.” гэж заасан бөгөөд дээрх соёрхон баталсан буюу нэгдэн орсон Олон улсын гэрээнүүдийн хувьд Үндсэн хуульд нийцэж байгаа эсэхэд Үндсэн хуулийн цэц хяналт хийх боломжийг хууль тогтоогч батлагдсан цаг хугацааны хориглолт хийснээрээ хязгаарласан байна.

Мөн Үндсэн хуулийн Хавсралт хуулийн Тавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын Үндсэн хууль хүчин төгөлдөр болох хүртэл дагаж мөрдөж ирсэн бүх хуулийг мөнхүү Үндсэн хуульд харшлахгүй бол цаашид хүчин төгөлдөр дагаж мөрдөнө.”, мөн 3 дахь хэсэгт “Монгол Улсын Үндсэн хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн мөнхүү Үндсэн хуульд харшилсан хууль болон эрх зүйн бүх акт, тэдгээрийн заалтыг хүчингүй болсонд тооцно.” гэж зааснаас үзвэл хууль тогтоогч ердийн хууль соёрхон баталсан буюу нэгдэн орсон Олон улсын гэрээг Үндсэн хуульд нийцүүлэх үүрэгтэй бөгөөд Үндсэн хуульд нийцсэн эсэхэд Үндсэн хуулийн цэц хяналт хийх эрх зүйн орчныг бүрдүүлэх үүрэгтэй байхаар байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Нэгдүгээр зүйлийн 2 дахь хэсэгт “Ардчилсан ёс, шударга ёс, эрх чөлөө, тэгш байдал, үндэсний эв нэгдлийг хангах, хууль дээдлэх нь төрийн үйл ажиллагааны үндсэн зарчим мөн.” гэж тунхаглан заасан байдаг ба энэхүү зарчим шаардлага нь хууль тогтоох эрх мэдэл бүхий байгууллагын ажиллах үеийн нөхцөл байдал, нийгмийн хэрэгцээ шаардлага, хүсэл сонирхлоос шалтгаалан түүний баталсан ердийн хуулийн хооронд зөрчил хийдлийг үүсгэсээр ирсэн нь Үндсэн хуулийн хяналтын байгууллага зайлшгүй орших шалтгаан нөхцөлийг бүрэлдүүлсэн байдаг.

Энэхүү зөрчил хийдлийг хууль дээдлэх зарчим, шударга ёс, тэгш байдлын зарчимд нийцүүлэн өнөөгийн эрх зүйн системд олсон ололтоос ухраахгүй суурь зарчимдаа нийцүүлэн шийдвэрлэх нь Үндсэн хуулийн хяналтын байгууллага буюу Үндсэн хуулийн цэцийн үндсэн зорилго болно.

Өнөөдрийн хүчин төгөлдөр үйлчилж буй Үндсэн хуулийн агуулгаар Монгол Улсад хүчин төгөлдөр үйлчилж буй хууль, соёрхон баталсан буюу нэгдэн орсон Олон улсын гэрээ нь Үндсэн хуульд бүрнээ нийцэх ёстой юм бол түүнийг нийцсэн эсэхийг хянах эрх Үндсэн хуулийн цэцэд олгогдсон байх нь зүй ёсны асуудал болно.

Өөрөөр хэлбэл, Хууль тогтоогч засаглалын салаа мөчрийн эрх, үүрэг, хариуцлагыг тогтоох, нийгмийн харилцааг зохицуулсан хэм хэмжээг хуулиар тодорхойлохдоо Үндсэн хуулийн агуулга зарчимд нийцүүлэхээс гадна Үндсэн хуульд хэрхэн нийцсэнийг хараат бус мэргэжлийн, дээд хяналт болох Үндсэн хуулийн цэц хяналт хийх боломж нөхцөлийг бүрдүүлсэн байх нь нэг талаар хууль тогтоогчид Үндсэн хуулиар оноосон үүрэг, нөгөө талаар Үндсэн хуулийн цэцийн Үндсэн хуулиар олгогдсон бүрэн эрх юм.

Иймд Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Цэц зөвхөн Үндсэн хууль хүчин төгөлдөр болж үйлчилсэн 1992 оны 2 дугаар сарын 12-ны өдрөөс хойш гарсан хууль тогтоомж болон албан тушаалтны үйл ажиллагаатай холбогдсон маргааныг хянан шийдвэрлэнэ.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын Үндсэн хуулийн цэц бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа мөн.”, Далдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага, иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино.” гэснийг тус тус зөрчсөн эсэхийг хянан шийдвэрлэж өгнө үү.” гэсэн мэдээлэл ирүүлсэн байна.

Тав. Монгол Улсын Их Хурлын итгэмжлэгдсэн төлөөлөгч, Улсын Их Хурлын гишүүн Л.Мөнхбаатар Үндсэн хуулийн цэцэд ирүүлсэн тайлбартаа:

“Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 1 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт Үндсэн хуулийн цэц нь Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрхтэй байгууллага, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа мөн болохыг дурдаад мөн зүйлийн 2 дахь хэсэгт “Цэцийн үйл ажиллагааны зарчим, арга хэлбэр, зохион байгуулалт, бүрэн эрхийг Монгол Улсын Үндсэн хууль, энэ хуулиар тодорхойлно.” гэж тусгасан. Өөрөөр хэлбэл, Үндсэн хуулийн цэц нь Үндсэн хуулийн үзэл санааны үүднээс, түүнд тусгагдсан зохицуулалтын агуулга, зарчмын хүрээнд шийдвэрээ гаргана.

Энэ хүрээнд Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Цэц зөвхөн Үндсэн хууль хүчин төгөлдөр болж үйлчилсэн 1992 оны 2 дугаар сарын 12-ны өдрөөс хойш гарсан хууль тогтоомж болон албан тушаалтны үйл ажиллагаатай холбогдсон маргааныг хянан шийдвэрлэнэ.” гэж тусгагдсан. Улсын Их Хурал хууль тогтоох, хуульд нэмэлт, өөрчлөлт оруулах онцгой бүрэн эрхийнхээ хүрээнд Үндсэн хууль батлагдсаны дараа Бүгд Найрамдах Монгол Ард Улсын Ардын Их Хурлаас 1992 оны 1 дүгээр сарын 16-ны өдөр баталсан Монгол Улсын Үндсэн хуулийн Хавсралт хуулийн Тавдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Гагцхүү хуулиар зохицуулж байхаар Монгол Улсын Үндсэн хуульд заасан харилцааг тэр тухай шинэ хууль батлан гаргах хүртэл хугацаанд уул харилцааг зохицуулж ирсэн хууль, эрх зүйн бусад актын заалтаар зохицуулна. Үүнтэй холбогдуулан Монгол Улсын Үндсэн хуульд заасан хуулиудыг Улсын Бага Хурлаас тогтоосон хуваарийн дагуу 1993 онд багтаан батлан гаргана.” гэж, мөн зүйлийн 4 дэх хэсэгт “Хууль



тогтоомжийг Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэн бүрэн шинэчлэх ажлыг 1996 онд багтаан хийж дуусгана.” гэж хуульчилсан. Өөрөөр хэлбэл Улсын Их Хурал өөрийн онцгой бүрэн эрхийнхээ хүрээнд Үндсэн хуулийн суурь зарчмуудыг хэрэгжүүлэхийн тулд нарийвчилсан зохицуулалт бүхий органик хууль батлан гаргах үүргийг хуулиар хүлээсэн байна.

Үндсэн хуулийн тулгуур зарчим, үзэл санааг гажуудуулахгүйгээр Үндсэн хуулийн заалтыг бусад хуулийн заалтаар баяжуулан, хөгжүүлж нийгмийн харилцааг нарийвчлан зохицуулснаар Үндсэн хууль өөрөө амьдрах чадвартай байж, нийгмийн харилцааг зохицуулах үүргээ гүйцэтгэдэг.

Үндсэн хуульчилсан дээрх асуудлыг Улсын Их Хурал органик хууль буюу Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт тодруулан хуульчилсан нь Үндсэн хуулийн заалтад халдсан хэрэг бус харин Үндсэн хуулиар Улсын Их Хурлын бүрэн эрхэд онцгойлон хамааруулсан асуудлын эрх зүйн хамгаалалтыг бэхжүүлэн тогтоосон гэж үзэж байна.

Мэдээлэл гаргагчдын мэдээлэлд “... Засгийн газрын 2019 оны 3 дугаар сарын 06-ны өдрийн 91 дүгээр тогтоолоор “Эрдэнэт үйлдвэр” ХХК-д онцгой дэглэмийг тогтооходоо БНМАУ-ын Бага хурлаас 1991 оны 1 дүгээр сарын 04-ний өдөр баталсан Монгол Улсын Засгийн газарт эрх олгох тухай ... хуулийг үндэслэсэн байдаг ...” гэж дурдсан байна.

Тус агуулгын хүрээнд Үндсэн хуулийн цэц нь Үндсэн хуулийн холбогдох хэсгийг зөрчсөн, зөрчөөгүй эсэх талаар маргаан хянан шийдвэрлэх нь Үндсэн хуулийн Хорин тавдугаар зүйлтэй харшилдах нөхцөл бүрдэж байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлд зааснаар Үндсэн хуулийн цэц нь Үндсэн хуулийг зөрчсөн эсэх тухай шийдвэрийг хянаж дүгнэлт гаргах бөгөөд шаардлагатай бол дахин хянаж, эцэслэн шийдвэрлэдэг. Харин Монгол Улсын Засгийн газарт эрх олгох тухай хууль нь Үндсэн хуулийн цэцийн тухай хуулиар олгосон гол үүргээс хэтэрсэн гэж үзэж болохоор байна. Өөрөөр хэлбэл Цэцийн гол үүрэг бол 1992 оны Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах маргааныг магадлан шийдвэрлэх чиг үүрэгтэй буюу Үндсэн хуулийн суурь зарчмыг л хамгаалах үүрэг хүлээнэ. Ердийн хуулиуд бол хууль дээдлэх зарчмын дагуу Үндсэн хуулийн суурь үзэл баримтлалд нийцэн гарах ёстой ба Үндсэн хуулийг дэлгэрүүлж буй хэрэг гэж үздэг тул түүнээс өмнөх Үндсэн хуулийн үзэл баримтлалд нийцсэн, дэлгэрүүлж буй хуулиудыг Цэц шууд өнөөгийн Үндсэн хуульд нийцсэн эсэхийг хянах боломжгүй юм.

Үндсэн хуулийн цэцийн эрх хэмжээ, харьяалан шийдвэрлэх асуудлыг Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсэг,

Монгол Улсын Үндсэн хуулийн цэцийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 2, 3 дахь хэсэг, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 13, 14 дүгээр зүйлээр тус тус зохицуулсан байна.

Үндсэн хуулийн цэц нь Үндсэн хуульд дээд хяналт тавих субъект болохын хувьд түүний хяналтын цар хүрээг Үндсэн хуулиар тогтоодог учир тус маргааныг хянан шийдвэрлэх нь цэцийн харьяалан шийдвэрлэх асуудалд хамаарахгүй тул Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэг, Жаран зургадугаар зүйлийн 1, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийг зөрчөөгүй гэж үзэж байна.” гэжээ.

ҮНДЭСЛЭЛ:

1. Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын Үндсэн хуулийн цэц бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа мөн.” хэмээн хуульчилж Үндсэн хуулийн цэцийн бүрэн эрхийг тодорхойлсон байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн цэц нь Үндсэн хуулийн суурь үзэл баримтлал, үндсэн бүтцэд нийцүүлэн Үндсэн хууль ёсыг хамгаалж, Монгол Улсын Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих бүрэн эрхтэй.

Монгол Улсын Үндсэн хуулийн Хавсралт хуулийн Тавдугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Монгол Улсын Үндсэн хууль хүчин төгөлдөр болох хүртэл дагаж мөрдөж ирсэн бүх хуулийг мөнхүү Үндсэн хуульд харшлахгүй бол цаашид хүчин төгөлдөр дагаж мөрдөнө.”, мөн зүйлийн 3 дахь хэсэгт “... Үндсэн хуульд харшилсан хууль болон эрх зүйн бүх акт, тэдгээрийн заалтыг хүчингүй болсонд тооцно.”, 4 дэх хэсэгт “Хууль тогтоомжийг Монгол Улсын Үндсэн хуульд нийцүүлэн бүрэн шинэчлэх ажлыг 1996 онд багтаан хийж дуусгана.” гэж тус тус заасан боловч Монгол Улсын Их Хурлын Тамгын газраас ирүүлсэн “Мэдээлэл хүргүүлэх тухай” албан бичигт Монгол Улсын Үндсэн хууль хүчин төгөлдөр мөрдөгдөж эхлэхээс өмнөх хугацаанд баталж, өнөөг хүртэл хүчин төгөлдөр үйлчилж байгаа 9 хууль байгаа талаар дурджээ.

Монгол Улсын Үндсэн хуулийн Хавсралт хуулийн дагуу Үндсэн хуульд нийцүүлэх арга хэмжээг хууль тогтоогчийн зүгээс аваагүй, эсхүл Үндсэн хуульд нийцсэн гэж үзэж хэвээр үлдээсэн хууль тогтоомж, түүний хэм хэмжээг Үндсэн хуульд нийцсэн эсэхийг хянан шийдвэрлэх хууль зүйн боломжгүй байна.

2. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Цэц зөвхөн Үндсэн хууль хүчин төгөлдөр болж үйлчилсэн 1992 оны 2 дугаар сарын 12-ны өдрөөс хойш гарсан хууль тогтоомж болон албан тушаалтны үйл ажиллагаатай



холбогдсон маргааныг хянан шийдвэрлэнэ.” гэж хуульчилсан нь Үндсэн хуулийн цэцийн эрх хэмжээг цаг хугацааны хүчин зүйлээр үндэслэлгүй хязгаарлаж, үндэсний эрх зүйн нэгдмэл орон зайг үгүйсгэсэн байна.

Ийнхүү Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 4 дэх хэсгийн зохицуулалт нь Монгол Улсын Үндсэн хуулиар тодорхойлсон Үндсэн хуулийн цэцийн Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналтыг тавих бүрэн эрхийг хязгаарласан байх тул Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийг тус тус зөрчсөн гэж үзэх үндэслэлтэй байна.

3. Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлд Үндсэн хуулийн цэцийн харьяалан шийдвэрлэх маргаан, түүнийг хянан шийдвэрлэх нийтлэг журмыг, Далдугаар зүйлийн 2 дахь хэсэгт Үндсэн хуулийг дагаж мөрдөх хугацааг тус тус тогтоосон байна. Иймд Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 4 дэх хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Жаран зургадугаар зүйлийн 4, Далдугаар зүйлийн 2 дахь хэсгийг тус тус зөрчсөн гэх үндэслэл тогтоогдохгүй байна.

4. Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 3 дахь заалтад Үндсэн хуулийн цэцээс Монгол Улсын Үндсэн хуулийг зөрчсөн эсэхийг хянан шийдвэрлэх албан тушаалтныг нэрлэн заасан болохыг тэмдэглэх нь зүйтэй байна.

Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйл, Жаран зургадугаар зүйлийн 1 дэх хэсэг, мөн зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалт, Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 31, 32 дугаар зүйлийг тус тус удирдлага болгон

МОНГОЛ УЛСЫН ҮНДСЭН ХУУЛИЙН НЭРИЙН ӨМНӨӨС ДҮГНЭЛТ ГАРГАХ нь:

1. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Цэц зөвхөн Үндсэн хууль хүчин төгөлдөр болж үйлчилсэн 1992 оны 2 дугаар сарын 12-ны өдрөөс хойш гарсан хууль тогтоомж болон албан тушаалтны үйл ажиллагаатай холбогдсон маргааныг хянан шийдвэрлэнэ.” гэж заасан нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран дөрөвдүгээр зүйлийн 1 дэх хэсгийн “Монгол Улсын Үндсэн хуулийн цэц бол Үндсэн хуулийн биелэлтэд дээд хяналт тавих, түүний заалтыг зөрчсөн тухай дүгнэлт гаргах, маргааныг магадлан шийдвэрлэх бүрэн эрх бүхий байгууллага, Үндсэн хуулийг чандлан сахиулах баталгаа мөн.”, Далдугаар зүйлийн 1 дэх хэсгийн “Үндсэн хуульд хууль, зарлиг, төрийн байгууллагын бусад шийдвэр, нийт байгууллага,

иргэний үйл ажиллагаа бүрнээ нийцсэн байвал зохино.” гэж заасныг тус тус зөрчсөн байна.

2. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 4 дэх хэсэг нь Монгол Улсын Үндсэн хуулийн Жаран зургадугаар зүйлийн 1 дэх хэсэгт “Үндсэн хуулийн цэц нь Үндсэн хуулийг зөрчсөн тухай маргааныг иргэдийн өргөдөл, мэдээллийн дагуу өөрийн санаачилгаар буюу Улсын Их Хурал, Ерөнхийлөгч, Ерөнхий сайд, Улсын дээд шүүх, Улсын ерөнхий прокурорын хүсэлтээр хянан шийдвэрлэнэ.”, Жаран зургадугаар зүйлийн 2 дахь хэсгийн 1 дэх заалтад “хууль, зарлиг, Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн бусад шийдвэр, түүнчлэн Засгийн газрын шийдвэр, Монгол Улсын олон улсын гэрээ Үндсэн хуульд нийцэж байгаа эсэх;”, мөн зүйлийн 4 дэх хэсэгт “Хууль, зарлиг, Улсын Их Хурал, Ерөнхийлөгчийн бусад шийдвэр, түүнчлэн Засгийн газрын шийдвэр, Монгол Улсын олон улсын гэрээ нь Үндсэн хуульд нийцээгүй гэж Үндсэн хуулийн цэц шийдвэр гаргавал зохих хууль, зарлиг, батламж, шийдвэр хүчингүй болно.”, Далдугаар зүйлийн 2 дахь хэсэгт “Монгол Улсын Үндсэн хуулийг 1992 оны хоёрдугаар сарын 12-ны өдрийн 12 цаг буюу арван долдугаар жарны усан бичин жилийн хаврын тэргүүн хар барс сарын шинийн есний идрийн барилдлагаатай өлзийт сайн шар морин өдрийн морин цагаас эхлэн улс даяар дагаж мөрдөнө.” гэж заасныг тус тус зөрчөөгүй байна.

3. Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 15 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт “Цэц зөвхөн Үндсэн хууль хүчин төгөлдөр болж үйлчилсэн 1992 оны 2 дугаар сарын 12-ны өдрөөс хойш гарсан хууль тогтоомж болон албан тушаалтны үйл ажиллагаатай холбогдсон маргааныг хянан шийдвэрлэнэ.” гэснийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 32 дугаар зүйлийн 4 дэх хэсэгт заасны дагуу 2020 оны 4 дүгээр сарын 15-ны өдрөөс эхлэн түдгэлзүүлсүгэй.

4. Энэхүү дүгнэлтийг Үндсэн хуулийн цэцэд маргаан хянан шийдвэрлэх ажиллагааны тухай хуулийн 36 дугаар зүйлийн 2 дахь хэсэгт заасны дагуу хүлээн авснаас хойш 15 хоногийн дотор хэлэлцэж, хариу ирүүлэхийг Улсын Их Хуралд уламжилсугай.

ДАРГАЛАГЧ

Ш.ЦОГТОО

ГИШҮҮД

**Г.ТУУЛХҮҮ
Ш.СОЛОНГО
Ц.НАНЗАДДОРЖ
Г.БАЯСГАЛАН**



МОНГОЛ УЛСЫН ОЛОН УЛСЫН ГЭРЭЭ

МОНГОЛ УЛС

болон

ОЛОН УЛСЫН ХӨГЖЛИЙН АССОЦИАЦИ

хоорондын

Санхүүжилтийн хэлэлцээр

(Мал аж ахуйн эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх төсөл)

ЗЭЭЛИЙН ДУГААР 6508-MN

САНХҮҮЖИЛТИЙН ХЭЛЭЛЦЭЭР

Энэхүү Хэлэлцээрийг Монгол Улс (“Хүлээн авагч”) болон Олон улсын хөгжлийн ассоциаци (“Ассоциаци”) хооронд гарын үсэг зурсан өдөр байгуулав. Хүлээн авагч болон Ассоциаци хооронд дараах зүйлсийг хэлэлцэн тохиролцов. Үүнд:

1 ДҮГЭЭР ЗҮЙЛ — ЕРӨНХИЙ НӨХЦӨЛҮҮД, НЭР ТОМЬЁОНУУД

- 1.01. Ерөнхий нөхцөлүүд нь (энэхүү Хэлэлцээрийн Хавсралтад заагдсан) энэхүү Хэлэлцээрт үйлчлэх ба түүний салшгүй хэсэг мөн.
- 1.02. Хэлэлцээрт өөрөөр заагаагүй бол Хэлэлцээрт том үсгээр тэмдэглэгдсэн нэр томьёонууд нь Ерөнхий нөхцөлүүд эсхүл энэхүү Хэлэлцээрийн хавсралтад заасан утгыг илэрхийлнэ.

2 ДУГААР ЗҮЙЛ — САНХҮҮЖИЛТ

- 2.01. Ассоциаци нь Хэлэлцээрийн Хуваарь 1-т тодорхойлсон төслийг (“Төсөл”) санхүүжүүлэхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор Хүлээн авагчид Ерөнхий нөхцөлүүдийн дагуу хөнгөлөлттэй зээлд тооцогдох хорин нэгэн сая найман зуун мянган зээлжих тусгай эрх (ЗТЭ 21,800,000¹)-тэй тэнцэх (түүнчлэн “зээл” болон “санхүүжилт” гэх) хэмжээний зээл олгохыг зөвшөөрсөн.
- 2.02. Хүлээн авагч энэхүү Хэлэлцээрийн Хуваарь 2-ын III дахь хэсэгт заасны дагуу санхүүжилтийн хөрөнгийг зарцуулах боломжтой.
- 2.03. Санхүүжилтийн ашиглагдаагүй үлдэгдэлд тооцогдох хөрөнгө нөөцлөн баталгаажуулсны хураамжийн дээд хэмжээ жилийн нэг хувийн хагас (1%-ийн 1/2) байна.
- 2.04. Зээлийн ашигласан үлдэгдэлд тооцогдох үйлчилгээний хураамж жилийн нэг хувийн дөрөвний гурав (1%-ийн 3/4) байна.

¹ ЗТЭ-ийн үнийн дүнг тооцохдоо хэлэлцээ хийсэн сарын өмнөх сарын сүүлийн өдрийн ам.доллар/ЗТЭ-ийн валютын ханшийг авч ашигласан болно (2019 оны 10 дугаар сарын 31-ний байдлаар 1 ам.доллар = 0.72496 ЗТЭ).



- 2.05. Зээлийн ашигласан үлдэгдэлд тооцогдох зээлийн хүү жилийн нэг зууны хорин таван хувь (1.25%) байна.
- 2.06. Төлбөр хийх өдөр нь жил бүрийн 2 дугаар сарын 15 болон 8 дугаар сарын 15-ны өдөр байна.
- 2.07. Үндсэн зээлийг энэхүү Хэлэлцээрийн Хуваарь 3-т заасан эргэн төлөгдөх хуваарийн дагуу эргэн төлнө.
- 2.08. Төлбөр гүйцэтгэх мөнгөн тэмдэгт АНУ-ын доллар байна.

3 ДУГААР ЗҮЙЛ — ТӨСӨЛ

- 3.01 Хүлээн авагч төслийн зорилго, зорилтуудыг хангах үүргийг хүлээнэ. Үүнтэй холбогдуулан Хүлээн авагчийн зүгээс төслийн хэрэгжүүлэхдээ Хэлэлцээрийн Ерөнхий нөхцөлүүдийн 5 дугаар зүйл болон энэхүү Хэлэлцээрийн Хуваарь 2-ын заалтыг мөрдлөг болгоно.

4 ДҮГЭЭР ЗҮЙЛ — ХҮЧИН ТӨГӨЛДӨР БОЛОХ, ЦУЦЛАХ

- 4.01. Хүчин төгөлдөр болоход тавигдах нэмэлт нөхцөлүүдэд:
 - (а) Хүлээн авагч нь Ассоциацийн шаардлагад нийцсэн хэлбэр, агуулга бүхий Төсөл хэрэгжүүлэх зааврыг баталсан байна;
 - (б) Хүлээн авагч нь Ассоциацийн шаардлагад нийцсэн эрх үүрэг, бүрэлдэхүүн, ажлын даалгавар бүхий Төсөл хэрэгжүүлэх нэгжийг байгуулсан байна.
- 4.02. Энэхүү Хэлэлцээрийн хүчин төгөлдөр болох эцсийн хугацаа нь Хэлэлцээр байгуулагдсан өдрөөс хойш нэг зуун хорин (120) хоногийн дотор байна.
- 4.03. Ерөнхий нөхцөлүүдийн Хэсэг 10.05 (б) заалтын дагуу энэхүү Хэлэлцээрийн хүрээнд Хүлээн авагчийн хүлээх аливаа үүрэг хариуцлага (төлбөрийн үүрэг хариуцлагаас бусад) Хэлэлцээр байгуулагдсан өдрөөс хорин (20) жилийн дараа дуусгавар болно.

5 ДУГААР ЗҮЙЛ — ТӨЛӨӨЛӨГЧИД; ХАЯГ

- 5.01. Хүлээн авагчийн төлөөлөгч нь Сангийн сайд байна.
- 5.02. Ерөнхий нөхцөлүүдийн Хэсэг 11.01-ийн хувьд (а) Хүлээн авагчийн хаяг:
Сангийн яам
Засгийн газрын II дугаар байр
С.Данзангийн гудамж - 5/1Д
Улаанбаатар хот 15160
Монгол Улс
ба
(б) Хүлээн авагчийн цахим хаяг:
Факсын дугаар: 976-51-320247
- 5.03. Ерөнхий нөхцөлүүдийн Хэсэг 11.01-ийн хувьд (а) Ассоциацийн хаяг:



Олон улсын хөгжлийн ассоциаци
1818 H Street, N.W.
Washington, D.C. 20433
United States of America
ба

(б) Ассоциацийн цахим хаяг:
Телекс: 248423 (MCI)

Факс: 1-202-477-6391

Хэлэлцээрт гарын үсэг зурсан өдөр ХАРИЛЦАН ТОХИРОЛЦОВ.

МОНГОЛ УЛСЫГ ТӨЛӨӨЛЖ:

Эрх бүхий төлөөлөгч

Нэр: _____

Албан тушаал: _____

Огноо: _____

ОЛОН УЛСЫН ХӨГЖЛИЙН АССОЦИАЦИЙГ ТӨЛӨӨЛЖ:

Эрх бүхий төлөөлөгч

Нэр: _____

Албан тушаал: _____

Огноо: _____

ХУВААРЬ 1

Төслийн танилцуулга

Төслийн зорилго нь мал сүргийн эрүүл мэнд, үр ашиг болон Төсөл хэрэгжих газрууд дахь өртгийн сүлжээний эдийн засгийн эргэлтийг нэмэгдүүлэх, мөн онцгой нөхцөл байдал, гамшгийн үед шуурхай, үр дүнтэй хариу арга хэмжээ авч хэрэгжүүлэхэд оршино.

Төсөл нь дараах бүрэлдэхүүн хэсгүүдтэй. Үүнд:

Бүрэлдэхүүн хэсэг 1. Малын эрүүл мэндийн үйлчилгээ

1.1. *Институтийн болон хүний нөөцийн чадавхыг дээшлүүлэх.*

Доорх зорилтуудыг биелүүлэхэд чиглэсэн хөтөлбөр арга хэмжээг хэрэгжүүлнэ:

- (а) Мал сүргийн эрүүл мэндийн асуудлын тэргүүлэх зорилтууд, баримталж буй эрхзүйн баримт бичиг, дүрэм журам, бодлогыг хянах, үнэлэх, шаардлагатай бодлого, дүрэм журмыг

боловсруулах замаар үндэсний мал эмнэлэг, мал сүргийн эрүүл мэндийн тогтолцоог сайжруулах;

- (б) Мал эмнэлгийн тогтолцооны ажиллах хүчнийг давтан сургах, чадавхжуулах хөтөлбөрийг институтчилэх, мэргэжлийн ажиллах хүчний чадавхыг дээшлүүлэх, сургалтын материал боловсруулах, чадавхыг бэхжүүлэх хөтөлбөр хэрэгжүүлэх замаар малын эмч нар болон энэ салбарын мэргэжилтнүүдийн мэдлэг, ур чадварыг дээшлүүлэх; ба
- (в) Дэлхийн мал амьтны эрүүл мэндийн байгууллагаар мал эмнэлгийн үйлчилгээний хяналт, үнэлгээг хийлгүүлэх чадавхыг бэхжүүлэх дэмжлэгээр хангах, энэхүү үнэлгээний зөвлөмжийг хариу хангах үр дүнтэй механизмыг бий болгох, мал эмнэлгийн үйлчилгээнд тогтмол үнэлгээ хийхэд дэмжлэг үзүүлэх зорилгоор Мал эмнэлгийн ерөнхий газар (“МЭЭГ”)–т техникийн туслалцаа үзүүлэх замаар мал эмнэлгийн үйлчилгээний мониторинг, хяналтыг сайжруулах.

1.2. Малын өвчний тандалт ба хяналт, хүнсний аюулгүй байдал.

Доорх зорилтуудыг биелүүлэхэд чиглэсэн хөтөлбөр арга хэмжээг хэрэгжүүлнэ:

- (а) Эрсдэлд суурилсан хүнсний аюулгүй байдлын зааварчилгаа арга хэмжээ, халдварт өвчний судалгаа, хүнсний эрсдэлийн үнэлгээ, хүнсний аюулгүй байдлын стандартууд, дархлаажуулалтын төлөвлөгөө, малын өвчний тандалтын аргууд, өвчний хяналт, судалгаа зэрэг баримт бичгүүдийг боловсруулахад техникийн туслалцаа үзүүлэх болон малын өвчний хяналтын арга хэмжээнүүдийг авч хэрэгжүүлэх замаар хил дамнасан малын халдварт болон гоц халдварт өвчнөөс урьдчилан сэргийлэх, эрсдэлд суурилсан өвчний тандалт ба хяналтын тогтолцоог сайжруулах;
- (б) Мал эмнэлгийн лабораторийн байгууламж, дэд бүтцийн сүлжээг шинэчлэх, сайжруулах; ба
- (в) Малын халдварт болон гоц халдварт өвчингүй бус, тусгаарлагдсан аж ахуй байгуулах, бий болгоход чиглэсэн өвчнөөс урьдчилан сэргийлэх стратегиудыг бий болгох, хөгжүүлэх.

1.3. Мал сүргийн эрүүл мэндийг сайжруулах цахим арга хэрэгслүүд

Доорх зорилтуудыг биелүүлэхэд чиглэсэн хөтөлбөр арга хэмжээг хэрэгжүүлнэ:

- (а) Мал сүргийн эрүүл мэндийн мэдээлэл, малын гаралтай бүтээгдэхүүний чанарын баталгаа, гарал үүслийн мэдээллийн нэгдсэн системийг бэхжүүлэх;
- (б) Лабораторийн мэдээллийн удирдлагын системийг сайжруулах, нийтэд цацах;



- (в) Мал сүргийн хөдөлгөөний хяналт, малын гаралтай бүтээгдэхүүний чанар, хүнсний аюулгүй байдлын баталгааг бэхжүүлэх; ба
- (г) малыг ялган тэмдэглэх, бүртгэлжүүлэх тогтолцоог бэхжүүлэх.

1.4. Мал сүргийн эрүүл мэндийн эрсдэлийг удирдах орон нутгийн иргэдийн оролцоонд суурилсан санаачилгууд

Доорх зорилтуудыг биелүүлэхэд чиглэсэн хөтөлбөр арга хэмжээг хэрэгжүүлнэ:

- (а) Орон нутгийн иргэдийн оролцоонд суурилсан мал сүргийн эрүүл мэндийн эрсдэлийн удирдлагыг сайжруулах тогтолцоог турших; ба
- (б) Мал сүргийн эрүүл мэндийн эрсдэлийг олж тогтоох, мал эмнэлгийн чанартай үйлчилгээг орон нутагт оновчтой хүргэх аргачлалыг боловсруулах, хөгжүүлэх.

Бүрэлдэхүүн хэсэг 2: Өртгийн сүлжээний эдийн засгийн эргэлт

2.1. Мал сүргийн бүтээмж

Доорх зорилтуудыг биелүүлэхэд чиглэсэн хөтөлбөр арга хэмжээг хэрэгжүүлнэ:

- (а) Цөм сүргийг хөгжүүлэх, зохиомол хээлтүүлгийн нэгжүүдийг бий болгох, хөгжүүлэх замаар малын үржлийг сайжруулах;
- (б) Хувийн мал үржүүлгийн нэгжүүд ба/эсхүл орон нутгийн мал үржүүлэгч нарын чадавхыг бэхжүүлэх;
- (в) Мал сүргийн тэжээлийн шалгарсан туршлагауудыг нэвтрүүлэн, нутагшуулах, чадавхыг бэхжүүлэх замаар мал сүргийн бүтээмжийг сайжруулах; ба
- (г) Сүүний чиглэлийн кластерууд, малыг шахан бордох цэгүүд, малын өвчнөөр тайван тусгаарлагдсан аж ахуйг бий болгох замаар хагас эрчимжсэн, эрчимжсэн мал аж ахуйг дэмжин хөгжүүлэх.

2.2. Бүтээмжит түншлэл

- (а) Мал аж ахуйн өртгийн сүлжээнд тулгарч буй асуудлуудыг шийдвэрлэх шинэлэг арга замуудыг тодорхойлох, малчид, боловсруулах үйлдвэр, үйлчилгээний ажилтнууд, өртгийн сүлжээнд оролцогчдыг холбох нэгдсэн механизмыг бий болгох; ба
- (б) Өртгийн сүлжээг хөгжүүлэх бизнес төлөвлөгөөнүүдийг үр дүнд суурилсан дэд төслүүдийг хэрэгжүүлэх замаар малчид болон үйлдвэрлэгчдийн Бүтээмжит түншлэлийг дэмжих.

Бүрэлдэхүүн хэсэг 3: Төслийн хэрэгжилтийг дэмжих

Төслийн хэрэгжилтэд техникийн болоод үйл ажиллагааны туслалцаа үзүүлэх, төсөлд зааварчилгаа өгөх, ялангуяа дараах асуудлаар уялдаа холбоог хангахад дэмжлэг үзүүлэх. Үүнд: (а) нийгэм ба байгаль орчны аюулгүй байдлын удирдлага; (б) худалдан авах ажиллагааны төлөвлөлт, гэрээний удирдлага; (в) санхүүгийн удирдлага, зээлийн ашиглалт, аудит, (г) хяналт-шинжилгээ, үнэлгээ, олон нийтийн харилцаа.

Бүрэлдэхүүн хэсэг 4: Болзошгүй онцгой байдлын хариу арга хэмжээ

Болзошгүй гамшиг эсхүл онцгой байдлын үед авч болох хариу арга хэмжээ.

ХУВААРЬ 2

Төслийн гүйцэтгэл

I хэсэг. Хэрэгжилтийн зохион байгуулалт

А. Институтийн зохион байгуулалт

1. Хүлээн авагч нь төв болон орон нутгийн хэмжээнд Ассоциацийн шаардлагад нийцсэн бүрэлдэхүүн, чиг үүрэг, орон тоо, нөөц бололцоо бүхий Төсөл хэрэгжүүлэх бүтцийг төсөл хэрэгжих хугацаанд бүрдүүлж ажиллуулах ба энэ талаар Төсөл хэрэгжүүлэх зааварт заасан байна.
2. Доор зааснаар хязгаарлагдахгүйгээр Хүлээн авагч тал нь:
 - (а) Хүлээн авагч нь ХХААХҮЯ-ны Төрийн нарийн бичгийн даргаар ахлуулсан, Сангийн яам, ХХААХҮЯ, МЗЕГ-ын холбогдох нэгжийн албан тушаалтнуудын төлөөллөөс бүрдсэн, төслийн хэрэгжилтийг бодлогын чиглэл, удирдамжаар хангах чиг үүрэг бүхий Төслийн удирдах хороог ажиллуулна;
 - (б) ХХААХҮЯ-ны удирдлага дор төслийн өдөр тутмын үйл ажиллагааг хариуцсан Төсөл хэрэгжүүлэх нэгжийг ажиллуулах ба тус нэгж нь (i) жилийн үйл ажиллагааны төсөв, төлөвлөгөө боловсруулах, (ii) худалдан авах үйл ажиллагаа, санхүүгийн удирдлага, байгаль орчин, нийгмийн Аюулгүй удирдлага, (iii) төслийн хяналт- шинжилгээ, үнэлгээг хийх чиг үүрэгтэй;
 - (в) Хэлэлцээр хүчин төгөлдөр болсон өдрөөс хойш гурван (03) сарын дотор Ассоциацийн шаардлагад нийцэхүйц ажлын даалгавар болон шалгуурт нийцүүлэн төслийн хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх зорилгоор хамгийн багадаа нэг (1) зөвлөхийг томилж, ажиллуулна; мөн
 - (г) энэхүү хэсгийн 2-ын (в) заалтад дурдсан хэрэгжилтэд дэмжлэг үзүүлэх зөвлөхийг Ассоциацид хүлээн зөвшөөрөгдөхүйц хэлбэрээр ажиллуулна.



Б. Төсөл хэрэгжүүлэх заавар

Хүлээн авагч нь төслийг Төсөл хэрэгжүүлэх зааварт заасны дагуу (Төсөл хэрэгжүүлэх заавар (“ТХЗ”) дахь аливаа зүйл заалт энэхүү Хэлэлцээрийн заалттай зөрчилдөх тохиолдолд Хэлэлцээрийн заалт давуу үйлчилнэ) хэрэгжүүлэх ба Ассоциациас урьдчилан бичгээр зөвшөөрөл авалгүйгээр Төсөл хэрэгжүүлэх Зааврын зүйл заалтыг өөрчилж, шилжүүлж, хүчингүй болгож, хасаж, түдгэлзүүлэхгүй.

В. Жилийн үйл ажиллагааны төсөв, төлөвлөгөө

1. Хүлээн авагч нь ХХААХҮЯ-аар дамжуулан төсөл хэрэгжих хугацаанд төсвийн жил бүрийн 12 дугаар сарын 31-ний өдрийн дотор (эсхүл Ассоциациас тогтоосон хожуу өдөр) ирэх төсвийн жилд төслийн хүрээнд зохион байгуулагдах бүх үйл ажиллагаа, гарах зардлуудыг, тэр дундаа тэдгээрийн санхүүжилтийн эх үүсвэрийг тодорхойлсон байх ба энэхүү Хуваарийн Д бүрэлдэхүүн хэсэг дэх байгаль орчин, нийгмийн хамгаалалтай холбоотой авч хэрэгжүүлсэн болон хэрэгжүүлэхээр төлөвлөсөн арга хэмжээг тусгасан жилийн үйл ажиллагааны нэгдсэн төсөв, төлөвлөгөөг Ассоциацид хүргүүлж, зөвшөөрөл авна.
2. Хүлээн авагч нь төслийг Ассоциациас баталсан тухайн төсвийн жилд хамаарах жилийн үйл ажиллагааны төсөв, төлөвлөгөөний дагуу хэрэгжүүлэх ба ийнхүү батлагдсан жилийн үйл ажиллагааны төсөв, төлөвлөгөөний аливаа зүйл заалт энэхүү Хэлэлцээрийн заалттай зөрчилдөх тохиолдолд Хэлэлцээрийн заалт давуу үйлчилнэ.
3. Хүлээн авагч нь Ассоциациас урьдчилан бичгээр зөвшөөрөл авалгүйгээр жилийн үйл ажиллагааны төсөв, төлөвлөгөөнд ямарваа нэгэн өөрчлөлт оруулахгүй эсхүл оруулах зөвшөөрлийг олгохгүй.

Г. Бүтээмжит түншлэл

1. Төслийн 2.2-ийн (б) хэсгийн хэрэгжилтийг хангах үүднээс Хүлээн авагч нь ХХААХҮЯ-аар төлөөлүүлэн Төсөл хэрэгжүүлэх зааварт заасан шалгуур үзүүлэлтүүд болон зохион байгуулалт, зохицуулалтад нийцүүлэн Бүтээмжит түншлэлд Гүйцэтгэлд суурилсан дэд төсөлд хамрагдах боломжийг бүрдүүлж өгнө.
2. Дээр дурдсанаас гадна Гүйцэтгэлд суурилсан дэд төсөл бүр Хүлээн авагчийг төлөөлөн ХХААХҮЯ болон тухайн Бүтээмжит түншлэгч хооронд байгуулсан Бүтээмжит түншлэлийн гэрээний хүрээнд хийгдсэн байна. Бүтээмжит түншлэлийн гэрээ нь Төсөл хэрэгжүүлэх заавар болон Ассоциациас тавих нөхцөл, шаардлагад нийцсэн байх ба дараах зүйлийг тусгасан байна:
 - (а) Гүйцэтгэлд суурилсан дэд төслийн хүрээнд санхүүжүүлэх үйл

- ажиллагааг тодорхойлж, Бүтээмжит түншлэлийн талуудын оролцоо, хувь нэмэр;
- (б) Тухайн Бүтээмжит түншлэлийн хүлээх үүрэг. Үүнд:
- (i) үйл ажиллагааг ХХААХҮЯ-наас баталсан бизнесийн төлөвлөгөөний дагуу явуулах;
 - (ii) үйл ажиллагааг батлагдсан бизнесийн төлөвлөгөөний дагуу явуулахдаа холбогдох хууль журамд нийцүүлэх ба хэрэгжилтийг үр дүнтэй байлгах үүднээс техник, эдийн засгийн, санхүүгийн болон удирдлагын зохих зохицуулалт, тэр дундаа Төсөл хэрэгжүүлэх заавар, Аюулгүй ажиллагааны бодлого, Авлигын эсрэг журам зэрэг зээлийн хөрөнгө хүлээн авагчид хамааралтай бусад зохицуулалтад нийцүүлэх;
 - (iii) харилцан тохиролцсон үүрэг, хувь оролцоог тухай бүр түргэн шуурхай хангах эсхүл хангуулах замаар батлагдсан бизнесийн төлөвлөгөөг хэрэгжүүлэх;
 - (iv) Гүйцэтгэлд суурилсан дэд төслийн хүрээнд санхүүжүүлэх бараа, үйлчилгээний худалдан авалтыг Ассоциацид хүлээн зөвшөөрөгдсөн, Төсөл хэрэгжүүлэх зааварт нарийвчлан заасан зохицуулалтад нийцүүлэх;
 - (v) батлагдсан бизнес төлөвлөгөөний хэрэгжилт, зорилтуудын биелэлтэд Ассоциацид хүлээн зөвшөөрөгдсөн шалгуур үзүүлэлтийн дагуу хяналт тавих, тайлагнах;
 - (vi) Төсөл хэрэгжүүлэх зааварт заагдсан санхүүгийн удирдлагын шаардлагыг хангах;
 - (vii) бизнесийн төлөвлөгөөний дагуу явагдсан үйл ажиллагаа, түүнийг хэрэгжүүлсэн үйл явц, баримт бичиг болон холбогдох бүртгэлийг шалгах боломж нөхцөлөөр Хүлээн авагч болон Ассоциацийг хангах; ба
 - (viii) дээр дурдагдсан асуудлуудын хүрээнд Хүлээн авагч ба Ассоциацийн зүгээс шаардах бүхий л мэдээллийг бэлтгэж, хүргэх эсхүл бэлдүүлж, хүргүүлэх үүргийг хүлээнэ; мөн
- (в) Бүтээмжит түншлэлийн гэрээний дагуу хүлээсэн аливаа үүргийг ямарваа нэг байдлаар биелүүлээгүй тохиолдолд Хүлээн авагч ХХААХҮЯ-аар дамжуулан Бүтээмжит түншлэлийн Гүйцэтгэлд суурилсан дэд төслийн хөрөнгийг ашиглах эрхийг түр хаах, цуцлах эсхүл Гүйцэтгэлд суурилсан дэд төслийн хүрээнд авч ашигласан хөрөнгийг бүхэлд нь эсхүл хэсэгчлэн буцаан төлөхийг шаардах эрхтэй.
3. Хүлээн авагч нь ХХААХҮЯ-аар дамжуулан Бүтээмжит түншлэлийн гэрээний дагуу хүлээсэн эрх үүргээ биелүүлэхдээ Хүлээн авагч ба



Ассоциацийн эрх ашгийг хамгаалж, Санхүүжилтийн зорилгыг бүрэн хангахад анхаарна. Хүлээн авагч нь Ассоциациас урьдчилан бичгээр зөвшөөрөл авалгүйгээр Бүтээмжит түншлэлийн гэрээг заалтыг өөрчилж, шилжүүлж, хүчингүй болгож, хасаж, түдгэлзүүлэхгүй.

Д. Аюулгүй ажиллагааны бодлого

1. Хүлээн авагч дараах зүйлсийг баталгаажуулна:
 - (а) Аюулгүй ажиллагааны бодлогод заасны дагуу эрүүл ахуйн, аюулгүй ажиллагааны, байгаль орчин, нийгмийн Аюулгүй ажиллагааны бусад стандарт, горимыг төслийн хэрэгжилтэд баримтлал болгох;
 - (б) Байгаль орчин, нийгмийн удирдлагын хүрээнд заагдсанаар төслийн хүрээнд авч хэрэгжүүлэх үйл ажиллагаатай холбогдуулан Байгаль орчны удирдлагын төлөвлөгөө болон Уугуул иргэдийн төлөвлөгөө бэлтгэх шаардлагатай бол:
 - (i) тэрхүү Байгаль орчны удирдлагын төлөвлөгөө болон Уугуул иргэдийн төлөвлөгөөг (А) Байгаль орчин, нийгмийн удирдлагын хүрээнд нийцүүлэх боловсруулж, олон нийтэд мэдээлэх; (Б) төслийн үйл ажиллагааны улмаас нөлөөлөлд өртөж болзошгүй иргэдийн дунд зохих хэмжээнд хэлэлцүүлэг зохион байгуулж, түүнийгээ Ассоциацид танилцуулж, зөвшөөрөл авсан байх; (В) үйл ажиллагааг хэрэгжүүлэхээсээ өмнө тэрхүү төлөвлөгөөг батлуулсан байх; ба
 - (ii) Байгаль орчны удирдлагын төлөвлөгөө болон Уугуул иргэдийн төлөвлөгөөнд тавигдсан шаардлагуудыг хангах үүднээс Ассоциацийн хүлээн зөвшөөрөгдөх хэлбэрийн арга хэмжээг авч хэрэгжүүлнэ;
2. Хүлээн авагч нь: (а) Төслийн хүрээнд техник туслалцаа, зураг төсөл, чадавх бэхжүүлэх үйл ажиллагаатай холбогдуулан зөвлөх үйлчилгээ авахад тэрхүү зөвлөх үйлчилгээний үр дүнд байгаль орчин, нийгэм, эрүүл мэнд, аюулгүй ажиллагаанд нөлөөлөл учрахаар байгаа бол тэрхүү зөвлөх үйлчилгээг зөвхөн Ассоциацийн хянаж, зөвшөөрсөн ажлын даалгаврыг үндэслэж авна; (б) ажлын даалгаварт техник туслалцаа, зураг төсөл, чадавх бэхжүүлэх үйл ажиллагаанд Аюулгүй ажиллагааны болон Байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны зааварт заагдсан шаардлагыг харгалзан үзэх талаар тусгасан байна.
3. Ассоциациас бичгээр харилцан өөрөөр тохироогүй бол, Аюулгүй ажиллагааны арга хэрэгсэлд тусгагдсан нэг ч нөхцөл, заалтыг өөрчилж, шилжүүлж, хүчингүй болгож, хасаж, түдгэлзүүлэхгүй орхигдох, өөрчлөгдөх, хүчингүй болох, түдгэлзүүлэх, хасагдахгүй байхыг Хүлээн авагч хариуцан ажиллана. Аюулгүй ажиллагааны арга хэрэгслийн аливаа зүйл заалт энэхүү Хэлэлцээрийн заалттай

- зөрчилдөх тохиолдолд Хэлэлцээрийн заалт давуу үйлчилнэ.
4. Энэхүү Хэлэлцээрт тусгагдсан тайлагнахтай холбоотой бусад үүрэг хариуцлагаас гадна Хүлээн авагч нь:
 - (а) Төслийн Тайлангийн ажлын нэг хэсэг гэж үзэн өөрийн зүгээс Аюулгүй ажиллагааны арга хэрэгслийн биелэлттэй холбоотой мэдээллийг тогтмол хугацаанд цуглуулах, нэгтгэх болон Ассоциацид хүлээлгэн өгөхтэй холбоотой бүх арга хэмжээг авч, Ассоциациас шаардсан үед нэн даруй тусдаа тайлан болгон Ассоциацийн шаардлагад нийцсэн хэлбэр, байдлаар өгөх үүрэгтэй. Үүнд: (i) Аюулгүй ажиллагааны арга хэрэгслийн хэрэгжилтийн байдал, (ii) хэрэгжүүлэхэд ямар нэгэн саад, эсхүл аюул тулгарсан үед тухайн нөхцөл байдлын тухай, (iii) тухайн нөхцөл байдлыг шийдвэрлэх болон түүнээс урьдчилан сэргийлэхийн тулд авсан, эсхүл авах шаардлагатай арга хэмжээнүүдийн тухай; болон бусад мэдээллүүд багтана.
 - (б) Төслийн барилгын ажлыг хариуцаж буй аливаа нэгж (бүх инженер энд багтана), төслийн гүйцэтгэгчид болон туслан гүйцэтгэгчдээс бэлтгэж, хүргүүлсэн явцын тайлангийн хуулбарыг тэр даруй Ассоциацид хүргүүлэх үүрэгтэй.
 - (в) Төслийн үйл ажиллагааг байгаль орчин, нийгэм, олон нийт болон ажилтнуудад сөрөг нөлөө учруулах эрсдэл учирсан эсхүл эрсдэл учруулахуйц аливаа тохиолдол, ослын талаар Ассоциацид нэн яаралтай мэдэгдэх үүрэгтэй.
 5. Хүлээн авагч нь төслийн хүрээнд барилгын ажлын бүх худалдан авах ажиллагааны баримт бичгүүд болон гэрээнүүдэд төсөл гүйцэтгэгчид, туслан гүйцэтгэгчид болон хариуцагч нэгжүүдийн хүлээх үүрэг хариуцлагад дараах зүйлсийг хамруулсан байна: (а) Аюулгүй ажиллагааны арга хэрэгслийг тус тусын өөрт хамаарах хэсгүүдийг баримтлах; (б) ажиллах хүчний урсгал болон ажилтнуудын байрлах баазуудад тулгарч болох эрсдэл, нөлөөг тогтоох, хариуцаж ажиллахад чиглэсэн арга хэмжээг баталж, хэрэгжүүлэх; (в) холбогдох гэрээнүүдийн дагуу хэрэгжүүлж буй бүхий л барилгын ажлуудад хамаарах байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй байдал, хүйсэд суурилсан хүчирхийлэл, хүүхдийн эсрэг хүчирхийлэл зэрэгтэй холбоотой арга хэмжээнүүдийг нарийн тусгасан Ёс зүйн дүрмийг баталж, бүх ажилтнуудаар гарын үсэг зуруулан сахиулах.
 6. Хүлээн авагч нь төсөл хэрэгжих хугацааны турш Төслийн үйл ажиллагаанаас урган гарсан бүх гомдлыг үнэн шударгаар шийдвэрлэх үүднээс Ассоциацийн тавигдах шаардлагын хүрээнд гомдол шийдвэрлэх механизмыг хэрэгжүүлж, түүнийг хэрэглэх боломжийн талаар сурталчлах, мөн тухайн механизмаас гарсан шийдвэрүүдийг Ассоциациас тавигдах шаардлагын хүрээнд хэрэгжүүлэхэд хэрэгтэй бүхий л арга хэмжээг авах.



Е. Болзошгүй онцгой байдлын хариу арга хэмжээ

1. Төслийн Бүрэлдэхүүн 4-ийн (Болзошгүй онцгой байдлын хариу арга хэмжээ) хүрээнд тулгарч Болзошгүй онцгой байдлын хариу арга хэмжээг зөв хэрэгжүүлэхийн тулд, Хүлээн авагч нь доорх үүргүүдийг хүлээнэ:
 - (а) Онцгой байдлын хариу арга хэмжээг хэрэгжүүлэх арга хэмжээнүүдийг дэлгэрэнгүй тусгасан Болзошгүй онцгой байдлын хариу арга хэмжээний заавар боловсруулж (“заавар”), Ассоциацид хүргүүлэх. Эдгээр арга хэмжээнүүдэд: (i) Онцгой байдлын үед авч хэрэгжүүлэх хариу арга хэмжээ уялдуулж, аливаа тусгай зохион байгуулалттай арга хэмжээнүүд; (ii) Болзошгүй онцгой байдлын хариу арга хэмжээт багтаж болох тусгай үйл ажиллагаанууд, түүнд шаардлагатай хамаарах зардлууд (“Онцгой байдлын зардлууд”), болон түүнд хамаарах горимууд; (iii) Онцгой байдлын хариу арга хэмжээний санхүүгийн удирдлагын арга хэмжээнүүд; (iv) Онцгой байдлын хариу арга хэмжээний худалдан авах ажиллагааны арга болон горимууд; (v) Онцгой байдлын зардал гаргахад шаардагдах баримт бичгийн бүрдүүлэлт; (vi) Болзошгүй онцгой байдлын хариу арга хэмжээт Аюулгүй ажиллагааны арга хэрэгслүүд болон холбогдох бусад аюулгүй байдлыг хангах арга хэрэгслүүдийн хэрэглээ; (vii) Онцгой байдлын хариу арга хэмжээний зөв уялдаа холбоо болон хэрэгжилтийг хангахад чиглэсэн бусад арга хэмжээнүүд зэрэг багтана;
 - (б) Ассоциацийг зааврын төслийг хянаж судлах боломжоор хангах;
 - (в) Ассоциаци зөвшөөрсөн тохиолдолд Онцгой байдлын хариу арга хэмжээний зааврыг нэн даруй батлах;
 - (г) Онцгой байдлын хариу арга хэмжээний хэрэгжилт заавартай нийцэж байх, ба заавар болон энэ Хэлэлцээрийн заалтууд зөрчилдөх тохиолдолд, Хэлэлцээр давуу хүчин чадалтай байна; мөн
 - (д) Ассоциацийн зүгээс урьдчилан бичгээр өгсөн зөвшөөрөлгүйгээр зааварт заасан аль ч нөхцөлийг өөрчлөх, хүчингүй болгох, орхигдуулах, түдгэлзэх, хасахгүй.
2. Дээр дурдсан үйл ажиллагаануудтай холбогдуулан Хүлээн авагч нь доорх нөхцөлүүд хангагдахаас нааш Онцгой байдлын хариу арга хэмжээний хүрээнд ямар нэгэн үйл ажиллагаа явуулахгүй:
 - (а) Хүлээн авагч нь заагдсан аюулт үзэгдэл эсхүл онцгой байдал бий болсон болохыг тогтоосон, дурдсан холбогдох шаардлагыг байгалийн гамшиг, эсхүл онцгой байдалд арга хэмжээ авахын тулд дурдсан үйл

ажиллагаануудыг Болзошгүй онцгой байдлын хариу арга хэмжээт хамруулах хүсэлтээ Ассоциацид илгээсэн, Ассоциацийн зүгээс Хүлээн авагчийн тогтоосонтой санал нийлж, тухайн хүсэлтийг хүлээн авч зөвшөөрснөө Хүлээн авагчид мэдэгдсэн; мөн

- (б) Хүлээн авагч нь Зааврын дагуу дурдсан үйл ажиллагаануудад шаардагдаж болзошгүй Аюулгүй ажиллагааны бэлтгэлийг хангаж, мэдээлсэн, Ассоциацийн зүгээс дурдсан бүх арга хэрэгслүүдийг баталсан, Хүлээн авагч нь дурдсан арга хэмжээнүүдийн хүрээнд шаардагдах ажлуудын хэрэгжилтийг хангасан байх.

Бүлэг II. Төслийн хяналт-шинжилгээ, тайлан ба үнэлгээ

A. Төслийн тайлан

Хүлээн авагч нь хуанлийн нэг улирал дууссанаас дөчин тав (45) хоногийн дотор тухайн хуанлийн улирлын хугацаан дахь хэрэгжилтийн тайланг Ассоциацид хүргүүлнэ.

Б. Дунд хугацааны үнэлгээ

Энэхүү Хэлэлцээр хүчинтэй болсон өдрөөс хойш (а) ойролцоогоор гучин (30) сарын дотор Хүлээн авагч нь Ассоциацийн зүгээс шаардсан мэдээлэл болон тухайн тайлангийн хамрах хугацааны өмнөх хугацаанд төслийг хэрэгжүүлэхэд гарсан ахиц дэвшил бүхий дунд хугацааны тайланг бэлтгэж Ассоциацид хүргүүлнэ. Ингэхдээ Хүлээн авагч нь энэхүү А Хэсгийн дагуу авч хэрэгжүүлсэн хяналт-шинжилгээ, үнэлгээний үйл ажиллагаануудыг харгалзан үзсэн, Төслийн үр дүнтэй хэрэгжилтийг үргэлжлүүлэн хангахад авч хэрэгжүүлэх шаардлагатай арга хэмжээнүүд болон Төслийн зорилтуудын биелэлт зэргийг тусгасан байна. Мөн (б) Хүлээн авагч нь тайланг ирүүлсэн өдрөөс дөчин таван (45) хоногийн дотор тухайн дунд хугацааны тайланг Ассоциацийн хамт хянан үзэж, дунд хугацааны тайланд өгсөн дүгнэлт болон зөвлөмжүүд ба тухайн асуудал дахь Ассоциацийн байр суурь зэрэгт үндэслэн цаашид төслийг үргэлжлүүлэн үр дүнтэй хэрэгжүүлэхэд шаардлагатай арга хэмжээг авч хэрэгжүүлнэ.

Бүлэг III. Зээлийн эх үүсвэрийн ашиглалт

A. Ерөнхий зүйл

Ерөнхий нөхцөлүүдийн II дугаар зүйл болон Ассоциациас Хүлээн авагчид хүргүүлэх Ашиглалтын болон санхүүжилтийн зааврын дагуу Хүлээн авагч нь доорх хүснэгт дэх ангилал тус бүрд хуваарилагдсан зээлийн хэмжээ болон хамаарах санхүүжилтийн хувь хэмжээнд нийцүүлэн санхүүжилтийг татан авч Зөвшөөрөгдсөн зардлыг санхүүжүүлж болно.



Ангилал	Зээлийн хөрөнгийн хуваарилалт (ЗТЭ-ээр илэрхийлэв)	Зардлын санхүүжилтийн хувь хэмжээ (татвар оролцуулсан)
(1) Төслийн Бүрэлдэхүүн хэсэг 1, 2.1, 3 хамаарах бараа, ажил, зөвлөхийн болон зөвлөхийн бус үйлчилгээ, үйл ажиллагааны зардал, сургалт	17,440,000	100%
(2) Төслийн Бүрэлдэхүүн хэсэг 2.2-т хамаарах бараа, ажил, зөвлөхийн болон зөвлөхийн бус үйлчилгээ, Гүйцэтгэлд суурилсан дэд төслүүдийн санхүүжилт	4,360,000	100%
(3) Төслийн Бүрэлдэхүүн хэсэг 4-т хамаарах Онцгой байдлын зардлууд		
НИЙТ ДҮН	21,800,000	

Б. Хөрөнгө зарцуулах нөхцөлүүд, хугацаа

1. Дээрх А Хэсгээс үл хамааран дараах нөхцөлд зээлийн хөрөнгийн ашиглалт хийгдэхгүй. Үүнд:

- (а) Энэхүү Хэлэлцээрт гарын үсэг зурагдсан өдрөөс өмнө гарсан зардалд зээлийн хөрөнгийг ашиглахгүй ба харин Хэлэлцээрт гарын үсэг зурагдсан өдрөөс арван хоёр (12) хүртэлх сарын өмнө гарсан, Ангилал 1-д хамаарах 725,000 ЗТЭ-ээс хэтрэхгүй зардалд ашиглаж болно; эсхүл,
- (б) Ангилал (3)-т заасан онцгой байдлын зардлын хувьд Ассоциацийн зүгээс доорх нөхцөлүүд хангагдсан гэж үзсэн буюу энэ талаар Хүлээн авагчид тусгайлан мэдэгдсэнээс бусад тохиолдолд Зээлийн хөрөнгийн ашиглалт хийгдэхгүй:
 - (i) Хүлээн авагч нь шалгуур хангасан онцгой байдал тохиолдсон гэж үзэж Эрсдэлийн удирдлагын хэсгээс онцгой байдлын эсрэг шуурхай авах арга хэмжээг санхүүжүүлэх хүсэлтийг Ассоциацид хүргүүлсэн, Ассоциацийн зүгээс тохиолдсон онцгой байдал нь зохих шалгуурыг хангасан гэж үзэн Хүлээн авагчийн хүсэлтийг зөвшөөрч энэ тухай мэдэгдсэн байх;
 - (ii) Хүлээн авагч нь дурдагдсан үйл ажиллагаануудад шаардлагатай аюулгүйн арга хэрэгслүүдийг бэлтгэж, олон нийтэд зарласан, Хүлээн авагч нь дурдагдсан арга хэрэгслүүдийн хүрээнд хийх аливаа ажлуудыг уг Хуваарийн I.Д болон I.E бүлгүүдийн заалтуудыг баримтлан хэрэгжүүлсэн;
 - (iii) Эрсдэлийн удирдлагын бүлгийн уялдаа холбоог хангаж, хэрэгжүүлэх үүрэг бүхий нэгжүүдэд дурдагдсан үйл



- ажиллагаануудад зориулж уг Хуваарийн I.E бүлгийн заалтуудын дагуу хангалттай боловсон хүчин, нөөц байх; мөн
- (iv) Хүлээн авагч Зааврыг Ассоциацийн зүгээс зөвшөөрсний дагуу баталсан бөгөөд Болзошгүй онцгой байдлын хариу арга хэмжээт хамруулах болон түүнийг хэрэгжүүлэхэд тохиромжтой байхаар тооцон Зааврын заалтууд уг Хуваарийн I.E бүлгийн заалтуудтай нийцэж байх, нийцэхүйцээр байхаар шинэчлэгдсэн байх.
2. Дээр дурдсан 1-р зүйлийн заалтаас үл хамааран, Хүлээн авагч нь доорх зүйлсийг хариуцна. Үүнд:
- (a) Төслийн хэрэгжилтийн аль ч үед үр дүнд суурилсан дэд төслийг санхүүжүүлэх гүйлгээний хэмжээг гаргасан үр дүнгийн үнэлгээнд нийцүүлж тооцсон байх. Үр дүнгийн үнэлгээ тус бүрийг:
- (i) Ассоциациас зөвшөөрөгдсөн буюу ТХЗ-т тусгагдсан аргачлалын дагуу тооцож гаргасан байх бөгөөд Үр дүнгийн үнэлгээ нь: (А) Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яамнаас баталсан холбогдох ажлын (бизнесийн) төлөвлөгөөнд заасан зардлаас хэтрэхгүй байх; мөн (В) түүнд санхүүгийн өөр эх үүсвэрээс зарцуулсан үйл ажиллагааны зардлыг хамруулахгүй байх;
- (ii) Өмнөх зүйлд тусгагдсан шалгуур нөхцөлүүдэд нийцэж байхын тулд Ассоциациас зөвшөөрсөн хэлбэр, агуулгаар аргачлалыг үе үе хянаж, өөрчилж байх.
- (б) Бизнесийн төлөвлөгөөний хүрээнд хэрэгжүүлж буй үйл ажиллагаа нь Ассоциациас тавигдах шаардлагад нийцсэн ажлын даалгавар, чадвар, туршлага бүхий бие даасан шинжээчээр батлагдсан байхыг хариуцах; мөн
- (в) Дурдагдсан бие даасан шинжээчийн Ассоциацийн шаардлагад нийцсэн болон ТХЗ-т тусгагдсан хэлбэр, агуулга бүхий баталгаажуулалтын тайланг Үр дүнд суурилсан дэд төслүүдийн санхүүжилтийн хүсэлттэй хамт Ассоциацид хүргүүлнэ.
3. Төслийн дуусгавар болох хугацаа 2025 оны 6 дугаар сарын 30-ны өдөр байна.

ХУВААРЬ 3

Эргэн төлөлтийн хуваарь

Төлбөр хийх огноо	Эргэн төлөгдөх үндсэн зээлийн хэмжээ (хувиар илэрхийлэв)*
Жил бүрийн 2 дугаар сарын 15 ба 8 дугаар сарын 15	



2025 оны 2 дугаар сарын 15-наас эхлэн 2044 оны 8 дугаар сарын 15 хүртэл	1.65%
2045 оны 2 дугаар сарын 15-наас эхлэн 2049 оны 8 дугаар сарын 15 хүртэл	3.40%

* Ерөнхий нөхцөлүүдийн 3.05 (б) хэсгийн дагуу Ассоциациас өөрөөр заагаагүй бол дээрх хувь хэмжээ нь эргэн төлөгдөх үндсэн зээлийн хувь хэмжээг илэрхийлнэ.

ХАВСРАЛТ **Нэр томъёонууд**

1. “Аймаг” гэж Хүлээн авагчийн засаг захиргааны нэгжийг хэлнэ.
2. “Жилийн үйл ажиллагааны төсөв, төлөвлөгөө” буюу ЖҮАТТ гэсэн товчлол нь 1 дүгээр зүйлд дурдсан төлөвлөгөө ба төсвийг хэлнэ. Хуваарь 2-ын В хэсэгт тус төлөвлөгөөг Ассоциацийн бичгэн зөвшөөрлийг үндэслэн тухай бүр өөрчлөн шинэчлэх боломжтой.
3. “Авилгын эсрэг журам” гэж Ерөнхий нөхцөлүүдийн Хавсралт дахь 5 дугаар хэсэгт заагдсан 2006 оны 10 дугаар сарын 15-нд батлагдсан, 2011 оны 01 дүгээр сар болон 2016 оны 7 дугаар сарын 01-нд тус тус шинэчилсэн “Олон улсын сэргээн босголт, хөгжлийн банкны зээл болон Олон улсын хөгжлийн ассоциацийн зээл, буцалтгүй тусламжийн санхүүжилт бүхий төслүүдэд Луйвар, залилан, авилгаас урьдчилан сэргийлэх, тэмцэх журам”-ыг хэлнэ.
4. “Ангилал” гэж энэхүү Хэлэлцээрийн Хуваарь 2-ын III.A хэсэг дэх хүснэгтэд заагдсан ангиллыг хэлнэ.
5. “Болзошгүй онцгой байдлын удирдлагын заавар” гэж энэхүү Хэлэлцээрийн Хуваарь 2-ын 1.E.1-ийн (а)-д заасан зааврыг хэлэх ба энэхүү хэсэгт дурдсан Онцгой байдлын үед авах хариу арга хэмжээ бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд Хүлээн авагчийн батлан мөрдүүлэх зааврыг хэлнэ.
6. “Байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны заавар” гэж Дэлхийн банкны Байгаль орчин, эрүүл мэнд, аюулгүй байдлын зааврыг хэлэх ба www.ifc.org/ehsguidelines цахим холбоосноос тухай бүр шинэчлэгдсэн хувилбарыг үзэж болно.
7. “Хамаарах аюулт үзэгдэл эсхүл онцгой байдал” гэж Хүлээн авагчид эдийн засгийн ба/эсхүл нийгмийн ихээхэн сөрөг нөлөө үзүүлсэн эсхүл үзүүлэхүйц, байгалийн болоод хүний хүчин зүйлээс хамааралтай аюулт үзэгдэл эсхүл гамшгийг хэлнэ.
8. “Онцгой байдлын зардал” гэж энэхүү Хэлэлцээрийн Хуваарь 2-ийн I.E-ийн дагуу Болзошгүй онцгой байдлын удирдлагын зааварт тусгасан, Онцгой байдлын удирдлагын бүрэлдэхүүн хэсгийн хүрээнд шаардагдах зохих зардлуудыг хэлнэ.
9. “Онцгой байдлын үед авах хариу арга хэмжээ бүрэлдэхүүн хэсэг” гэж төслийн Бүрэлдэхүүн хэсэг 4-ийн хүрээнд хамаарах аюулт үзэгдэл

- эсхүл онцгой байдлын үед авч хэрэгжүүлэх тодорхой үйл ажиллагааг хэлнэ.
10. “Байгаль орчин нийгмийн удирдлагын хүрээ” гэж Хүлээн авагчийн Ассоциацийн шаардлагад нийцүүлэн боловсруулж, 2019 оны 10 дугаар сарын 19-ний өдөр баталсан, Ассоциацийн цахим хуудаснаа 2019 оны 11 дүгээр сарын 5-ны өдөр байршуулсан, Байгаль орчин , нийгмийн удирдлагын хүрээг хэлэх ба төслийн үйл ажиллагаанаас Байгаль орчин, нийгэмд үзүүлж болох эх боломжит эрсдэл, үр нөлөөг үнэлэх, илрүүлэх зарчим, дүрэм журмыг тогтоосон түүн дотор жендерт суурилсан хүчирхийлэл, бэлгийн мөлжлөг ба хүчирхийлэл зэрэг эрсдэлүүд болон сөрөг нөлөөг (эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны асуудлууд мөн багтана) илрүүлэх, үнэлгээ өгөхөд чиглэсэн зарчим, дүрэм, заавар, үйл ажиллагааны горим, жендерт суурилсан хүчирхийлэл, бэлгийн мөлжлөг, хүчирхийлэл, үндэстний цөөнхөд учирч болох боломжит сөрөг нөлөө, тэдэнд сөрөг нөлөө учирсан эсэхийг тогтоох, учирсан тохиолдолд хэрхэн зайлсхийх багасгах, тэдний хохирлыг барагдуулах зэрэг байгаль орчин, нийгмийн сөрөг эрсдэл, нөлөөнөөс зайлсхийх, түүнийг багасгах арга хэмжээнүүдийг батлах, тэдгээрийг хэрэгжүүлэхэд хэрэгтэй үйл явцын, төсвийн болон зохион байгуулалтын арга хэмжээнүүд, үйл ажиллагаанууд, түүнчлэн Төслийн үйл ажиллагаанаас гарах эрсдэл, нөлөөтэй холбогдох асуудлыг шийдвэрлэх үүрэг бүхий агентлаг эсхүл агентлагуудын тухай мэдээлэл зэргийг тусгана. Байгаль орчны, нийгмийн удирдлагын төлөвлөгөөг бэлтгэхэд зориулсан байх ба Хүлээн авагч нь Ассоциацийн зүгээс бичгээр урьдчилан ирүүлсэн зөвшөөрлийн дагуу тодорхой хугацаанд уг Хүрээнд өөрчлөлт оруулж болно.
 11. “Байгаль орчны удирдлагын төлөвлөгөө” гэж Ассоциацийн шаардлагад нийцсэн горим, шаардлагуудын хүрээнд Төслийн талбайн үйл ажиллагаанд зориулан боловсруулагдах арга хэрэгсэл юм. Уг төлөвлөгөөнд дурдагдсан үйл ажиллагааны хэрэгжилтийн явцын үеэр (а) байгаль орчин, нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөнөөс (эрүүл мэнд, аюулгүй ажиллагааны асуудлууд мөн багтана) зайлсхийх, багасгах эсхүл тэдгээрийг зөвшөөрөгдсөн түвшин хүртэл бууруулах зэрэг арга хэмжээнүүд; мөн (б) тэдгээр арга хэмжээнүүдийг хэрэгжүүлэхэд шаардлагатай ажлууд зэргийг дэлгэрэнгүй тусгасан байна. Дурдсан арга хэрэгслүүдэд Ассоциацийн зүгээс бичгээр урьдчилан ирүүлсэн зөвшөөрлийн дагуу өөрчлөлт оруулж болох ба “БОУТ” гэдэгт ийм бүхий л төрлийн БОУТ-нүүдийг хамруулан ойлгоно.
 12. “МЭЭГ” гэж Мал эмнэлгийн ерөнхий газар эсхүл түүний чиг үүргийг залгамжлагч байгууллагыг хэлнэ.
 13. “Ерөнхий нөхцөлүүд” гэж ОУХА-ийн Санхүүжилтийн Ерөнхий нөхцөлүүд буюу 2018 оны 12 дугаар сарын 14-нд батлагдсан ОУХА-ийн Хөрөнгө оруулалтын төслийн санхүүжилтийн Ерөнхий нөхцөлүүдийг хэлнэ.
 14. “Уугуул иргэд” гэж Хүлээн авагчийн газар нутагт харьяалах өвөрмөц,



- эмзэг, нийгэм соёлын онцгой шинж чанар бүхий дараах хэв шинжийг ямар нэгэн байдлаар агуулсан нийгмийн бүлгийг хэлнэ: (а) өвөрмөц уугуул соёл бүхий бүлгийн гишүүн бөгөөд тэдний өвөрмөц хэв шинж бусдад хүлээн зөвшөөрөгдсөн; (б) төсөл хэрэгжих бүсэд өвөг дээдсийн нутаг дэвсгэр, эсвэл газарзүйн хувьд ялгаатай орчин тойронтой, мөн тэдгээр нутаг дэвсгэр, орчин дахь байгалийн нөөц баялагтай нягт (нэгдсэн) холбоотой; (в) давамгайлсан нийгэм, соёлоос ялгаатай уламжлалт соёл, эдийн засаг, нийгэм болон улс төрийн зохион байгуулалттай; мөн (г) уугуул хэлтэй.
15. “Уугуул иргэдийн төлөвлөгөө” гэж Байгаль орчин, нийгмийн Аюулгүй удирдлагын дагуу Хүлээн авагчийн батлахаар төлөвлөж буй аливаа уугуул иргэдийн эрх ашгийг хамгаалах төлөвлөгөөг хэлэх ба төлөвлөгөө нь бүтэц, агуулгын хувьд Ассоциацийн шаардлагыг хангахуйц байх буюу төслийн үйл ажиллагаанд хамрагдаж буй уугуул иргэдийн хүртэх нийгэм, эдийн засгийн үр ашиг нь соёлын хувьд нийцтэй байх бөгөөд эдгээр үйл ажиллагааны хүрээнд Уугуул иргэдэд учирч болзошгүй аливаа сөрөг нөлөөллийг багасгах, зайлсхийсэн байх; энэхүү төлөвлөгөөг Ассоциацийн бичгэн зөвшөөрлийн дагуу тухай бүр өөрчилж болох ба үүнд тус төлөвлөгөөний аливаа хавсралт мөн багтана.
 16. “Сангийн яам” гэж Хүлээн авагчийн Сангийн яам эсхүл түүний чиг үүргийг залгамжлагч байгууллагыг хэлнэ.
 17. “ХХААХҮЯ” гэж Хүлээн авагчийн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн яам эсхүл түүний чиг үүргийг залгамжлагч байгууллагыг хэлнэ.
 18. “Үйл ажиллагааны зардал” гэж төслийн өдөр тутмын үйл ажиллагааг зохицуулах, удирдан зохион байгуулах, хянах гэх мэт үйлчилгээг хэрэгжүүлэхэд шаардагдах бараа буюу зөвлөхийн бус үйлчилгээний зардал, үүнд, тээврийн хэрэгслийн түрээс ба/ эсхүл засвар арчилгаа, тоног төхөөрөмж, албаны байрны түрээс, түлш, бичгийн хэрэгсэл, хэрэглээний зардлууд, харилцаа холбооны зардал (үүнд шуудан, үүрэн утас, интернэтийн зардал орно), тээвэр, орчуулга, хэвлэх, олшруулах зардал, банкны шимтгэл, хэвлэлийн болон сурталчилгааны зардал, даатгал, төсөлтэй холбоотой уулзалт, томилолт, зам хоног, унаа байрны болон гэрээт ажилтнууд болон бусад захиргааны зэрэг төсөлтэй шууд холбоотой зардлууд орно. Үүнд цалин, урамшуулал, нэмэлт төлбөр, мөнгөн шагнал ба бусад ижил төрлийн Хүлээн авагчийн төрийн үйлчилгээний зардал хамаарахгүй.
 19. “Бүтээмжийн үнэ цэнэ” гэж Бүтээмжит түншлэлийн бизнесийн төлөвлөгөөнд багтсан үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардагдах тодорхой зардал, өртгийг хэлнэ.
 20. “Гүйцэтгэлд суурилсан дэд төслүүд” гэж Бүтээмжит түншлэлийн бизнес төлөвлөгөөнд багтсан үйл ажиллагааг санхүүжүүлэхэд Хүлээн авагчийн зүгээс олгох зээлийн хөрөнгийг хэлэх бөгөөд дэд төслийн

- санхүүжилтийг Бүтээмжийн үнэ цэнэд үндэслэн тооцно.
21. “Хортон шавжтай тэмцэх төлөвлөгөө” гэж Ассоциацийн шаардлагад нийцэхүйцээр Хүлээн авагчийн боловсруулсан бөгөөд [хэрэгслийн нэр тухайн хэлээр], мөн Банкны цахим хуудсанд 2019 оны 11 дүгээр сарын 5-ны өдөр нийтлэгдсэн. Банкнаас урьдчилж бичгээр ирүүлсэн зөвшөөрлийн дагуу тодорхой хугацаанд шинэчлэгдэж болно.
 22. “Худалдан авах ажиллагааны журам” гэж 2016 оны 7 дугаар сард батлагдаж, 2017 оны 11 дүгээр сар, 2018 оны 8 дугаар сард шинэчлэгдсэн “Дэлхийн Банкны Худалдан авах ажиллагааны Хөрөнгө оруулалтын төслийн санхүүжилтийн Зээлдэгчдийн журам”-ын Ерөнхий нөхцөлийн хавсралтын 87-р зүйлийн зорилтод чиглэсэн.
 23. “Бүтээмжит түншлэл” гэж Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн ямаар дамжуулан ТХЗ-т тусгагдсан шаардлага, шалгуурын дагуу Хүлээн авагчийн сонгосон нэмүү өртгийн сүлжээ бий болгох шинэ шийдлийг хэрэгжүүлэхийн төлөө төр/хувийн хэвшлийн үйлчилгээ үзүүлэгч болон анхан шатны мал аж ахуй эрхлэгчийн хооронд байгуулсан хамтын ажиллагаа юм.
 24. “Бүтээмжит түншлэлийн гэрээ” гэж Бүтээмжит түншлэлийн бизнес төлөвлөгөөний үйл ажиллагаануудыг хэрэгжүүлэх, санхүүжүүлэхэд чиглэсэн Хүнс, хөдөө аж ахуй, хөнгөн үйлдвэрийн ямаар дамжуулан Хүлээн авагч болон шаардлага хангах Бүтээмжит түншлэлийн хоорондын гэрээ бөгөөд энэ төрлийн бүх гэрээг “Бүтээмжит түншлэлийн гэрээ”-нд хамруулан ойлгоно.
 25. “Төсөл хэрэгжих байршил” гэж Хүлээн авагчийн сонгосон аймгууд болох Баян-Өлгий, Увс, Ховд, Завхан, Хөвсгөл, Говь-Алтай, Баянхонгор, Булган, Орхон, Архангай, Өвөрхангай, Төв, Хэнтий, Сүхбаатар зэргийг хамруулан хэлэх бөгөөд эсхүл Ассоциацитай тохиролцсоны дагуу бусад аймгууд багтаж болно.
 26. “Төсөл хэрэгжүүлэх заавар” гэж уг Гэрээний 2 дугаар хуваарийн Бүлэг I.B-д тусгагдсан төслийг хэрэгжүүлэхэд зориулж Хүлээн авагчийн зүгээс баталсан заавар юм. Дараах дэлгэрэнгүй үйл ажиллагаа болон ажлын журмуудыг багтаасан байна: (а) Төслийн зохион байгуулалтын уялдаа холбоо болон өдөр тутмын гүйцэтгэл; (б) зарцуулалт болон санхүүгийн удирдлага; (в) худалдан авах ажиллагаа; (г) байгаль орчин, нийгмийн аюулгүй байдлын арга хэмжээнүүд; (д) мониторинг ба үнэлгээ, тайлан ба харилцаа холбоо; (е) шударга байдлын ажлын төлөвлөгөө, (ё) Бизнесийн төлөвлөгөө болон холбогдох Бүтээмжит түншлэлийг сонгохтой холбогдсон мөн Үр дүнд суурилсан урамшууллын шалгуур үзүүлэлтүүд, үнэлгээ, зөвшөөрөл, удирдлагын үйл ажиллагаанууд болон журмууд бүхий дэд заавар, мөн (ж) Төсөлд шаардагдах ийм төрлийн бусад захиргааны, санхүүгийн техникийн болон зохион байгуулалтын үйл ажиллагаанууд, журмууд. Өмнө дурдсанчлан Ассоциациас урьдчилж бичгээр ирүүлсэн зөвшөөрлийн дагуу тодорхой хугацаанд өөрчлөлт оруулж болох бөгөөд уг нэр томьёонд зааварт байх аливаа хуваарийг багтааж болно.



27. “Төсөл хэрэгжүүлэх нэгж” гэж энэхүү Хэлэлцээрийн Хуваарь 2-ын I.A.2.(б) бүлэгт тусгагдсан Хүлээн авагчийн үүсгэн байгуулж, ажиллуулах нэгж эсхүл түүний чиг үүргийн залгамжлагчийг хэлнэ.
28. “Төслийн удирдах хороо” гэж энэхүү Хэлэлцээрийн Хуваарь 2-ын I.A.2.(б) бүлэгт тусгагдсан Хүлээн авагчийн байгуулж, ажиллуулах хороо эсхүл түүний залгамжлагч байна.
29. “Аюулгүй ажиллагааны арга хэрэгслүүд” гэж БОНХХ, БОУТ, ХШТТ бөгөөд “Аюулгүй ажиллагааны арга хэрэгсэл” гэж ийм төрлийн ямар нэгэн аюулгүйн арга хэрэгслийг хэлнэ.
30. “Аюулгүй ажиллагааны бодлого” гэж Ассоциацийн үйл ажиллагааны бодлого (OPs) ба банкны горимууд (BPs), буюу OP/BP 4.01 (Байгаль орчны үнэлгээ), OP/BP 4.04 (Ан амьтан, ургамал), OP/BP 4.09 (Хортон шавжийн удирдлага), OP/BP 4.10 (Уугуул иргэд), OP/BP 4.11 (Биет соёлын өв), OP/BP 4.12 (Сайн дурын бус нүүлгэн шилжүүлэлт), OP/ BP 4.36 (Ой), and OP/BP 4.37 (Далангийн аюулгүй байдал) зэрэг орно; <https://policies.worldbank.org> цахим холбоосоос бүрэн эхээр нь үзэж болно.
31. “Гэрээ байгуулсан өдөр” гэж Хүлээн авагч ба Ассоциаци хоорондын гарын үсэг зурсан хоёр огнооны сүүлийн огноог хэлэх ба «Санхүүжилтийн хэлэлцээр хийсэн огноо» гэдэгтэй утга нэг хэрэглэгдэнэ.
32. “Сум” гэж Хүлээн авагчийн засаг захиргааны нэгж болох «аймаг»-ийн дэд нэгжийг хэлнэ.
33. “Сургалт” гэж төслийн хүрээнд зохион байгуулагдаж байгаа ажилчдад зориулагдсан сургалтын үйл ажиллагаа, семинар, сургалтын аялал гэх мэтэд шаардагдах бараа материал, үйлчилгээний зардал бөгөөд үүнд сургалтад оролцогсдын унаа, байр хоолны зардал, үйлчилгээний ажилтан, сургагч нарын хөлс, сургалтын байрны түрээс, сургалтын материал боловсруулах, олшруулах зардал болон сургалттай шууд холбогдох зардлууд орно. Үүнд зөвлөх үйлчилгээний хөлс, зөвлөхийн цалин, урамшуулал, мөнгөн шагнал, Хүлээн авагч талын нийгмийн үйлчилгээний шимтгэл зэрэг нь багтахгүй.
34. “Дэлхийн мал амьтны эрүүл мэндийн байгууллага” гэж 1924 оны 1 дүгээр сарын 25-ны өдөр Office International des Epizooties нэрийн дор байгуулагдсан, дэлхий дахинаа мал амьтны эрүүл мэндийг сайжруулах зорилготой төр засаг хоорондын байгууллага юм.

Хаяг:

“Төрийн мэдээлэл” эмхэтгэлийн редакц.
Улаанбаатар-14201, Төрийн ордон 124 тоот
И-мэйл: turiin_medelel@parliament.mn

Утас: 262420

Хэвлэлийн хуудас: 2.25

Индекс: 200003